



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДӨР, ДАВАА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-6</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>7-38</i>

1. Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа	7-14
2. Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	14-25
3. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/	25-38

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
9 дүгээр сарын 15-ны өдөр /Даваа гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 113 гишүүн хүрэлцэн ирж, 89.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 02 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Цэнгүүн;

Чөлөөтэй: С.Одонтуяа, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ч.Анар, Ж.Ганбаатар, С.Зулпхар, Ж.Энхбаяр;

Тасалсан: С.Лүндэг;

Хоцорсон: Б.Дэлгэрсайхан-02 минут, Т.Мөнхсайхан-01 минут, Б.Пунсалмаа-15 минут, О.Саранчулуун-09 минут, А.Ундраа-02 минут.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
нээлтийн ажиллагаа**

Танхимын баруун хойд талд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж;

Зүүн хойд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт;

Зүүн урд талд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, дэд дарга Ү.Амарбат, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, Менежментийн газрын дарга Т.Нармандах, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга Т.Төрболд, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дарга С.Далхаасүрэн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны дарга Б.Энхмөнх нар;

Урд талд Монгол Улсын Их Хурлын дарга асан Н.Багабанди, Р.Гончигдорж, С.Төмөр-Очир, Н.Энхбаяр, Ц.Нямдорж, Д.Лүндээжанцан, Д.Дэмбэрэл, З.Энхболд, М.Энхболд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Бямбажаргал, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Үйлстөгөлдөр, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Л.Цог, Б.Энэбиш, Н.Лувсанжав, Д.Сандаг-Очир, Ц.Цолмон, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Л.Өлзийсайхан, Д.Энхбат, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ нар;

Баруун урд талд Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид нар;

Танхимын дээд давхарт Монгол Улсад суугаа гадаад орнуудын элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Олон улсын байгууллагын төлөөлөгчид тус тус суудлаа эзэлсэн байв.

Танхимын баруун хойд, зүүн хойд болон урд хэсэгт байрлуулсан дэлгэц дээр “Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нээлт. 2025.09.15” гэсэн үг гарч байв.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганыг нээж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон нээлтийн ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нээлтийн ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Нээлтийн ажиллагаа 10 цаг 24 минутад өндөрлөв.

Үдээс өмнөх хуралдаан 22 минут үргэлжилж, 10 цаг 24 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 11 минутад эхлэв.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулах

Монгол Улсын иргэн О.Батхүү нийтийн ашиг сонирхлыг хөндсөн Үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2 хувийн татварыг хүчингүй болгох хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл ирүүлснийг Монгол Улсын 18 насанд хүрсэн 100,176 /нэг зуун мянга нэг зуун далан зургаа/ иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./14:15/

Хоёр.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын

гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ажлын 2 өдрийн завсарлага өгөв./14:49/

Уг асуудлыг 14 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025.09.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Л.Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Улсын Их Хурлын гишүүн, Батлан хамгаалахын сайд Д.Батлут, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Улсын Их Хурлын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрэм, Улсын Их Хурлын гишүүн, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Э.Батшугар, Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Ж.Чинбүрэн, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг, Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Авлигатай тэмцэх газрын дарга З.Дашдаваа, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Т.Жамбаажамц, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Н.Энхбаяр, мөн зөвлөлийн гишүүн Л.Гангэрэл, Ж.Дэлгэрсайхан, Л.Отгонтуяа, Р.Ринчинбазар, Н.Ууганбаатар, А.Энхбат, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга С.Заяадэлгэр, Монгол Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга Э.Батмөнх, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын

дарга Х.Сүрэнхорол, Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Анар, Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга Д.Эрдэнэтуяа, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Бизнесийн орчны бодлогын газрын дарга Л.Балчинлуvsан, Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга О.Мягмардорж, Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга Ц.Мөнхдэлгэр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төсвийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Төсвийн төслийн талаарх Төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус зөвлөлийн дарга Н.Энхбаяр нар танилцуулав.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ажлын 2 өдрийн завсарлага өгөв./15:33/

Уг асуудлыг 15 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Чуулганы хуралдааны хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 1 цаг 44 минут үргэлжилж, 126 гишүүнээс 118 гишүүн хүрэлцэн ирж, 93.7 хувийн ирцтэйгээр 15 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 02 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нээлтийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар, Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор, Засгийн газрын гишүүд, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга, нийслэлийн удирдлагууд зэрэг төрийн өндөр албан тушаалтнууд, Улсын Их Хуралд ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын удирдлага, Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсанаас хойш ажиллаж байсан Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга нар, Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газруудын тэргүүн нар оролцож байна. Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Эрхэм хүндэт ард иргэд ээ, Хүндэт зочид оо,

Өдгөөгөөс 35 жилийн өмнө 1990 оны 7 дугаар сарын 29-ний өдөр олон намын оролцоотой анхны ардчилсан сонгууль болж 426 депутаттай Ардын Их Хурал бүрдсэн билээ. Улмаар 53 гишүүнтэй Улсын Бага Хурал бий болж, анхдугаар хуралдаанаа мөн оны 9 дүгээр сарын 13-ны өдөр хийснээр Монгол Улсад байнгын ажиллагаатай парламентын тогтолцооны суурь тавигдсан түүхтэй. Үе үеийн парламентын гишүүд болон нийт ард иргэддээ Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 35 жилийн ойн баярын мэндийг Улсын Их Хурлын нэрийн өмнөөс өргөн дэвшүүлье.

Парламентын түүхийн гэрч болсон Улсын Бага Хурлын дарга Раднаасүмбэрэлийн Гончигдорж, Улсын Их Хурлын үе үеийн даргаар ажиллаж байсан Нацагийн Багабанди, Лхамсүрэнгийн Энэбиш агсан, Санжбэгзийн Төмөр-Очир, Намбарын Энхбаяр, Цэндийн Нямдорж, Данзангийн Лүндээжанцан, Дамдины Дэмбэрэл, Зандаахүүгийн Энхболд, Миеэгомбын Энхболд, Гомбожавын Занданшатар нарт болон Монгол Улсын Үндсэн хуулийг боловсруулан батлуулахад эрдэм оюунаа дайчлан үнэт өв бүтээсэн Улсын Бага Хурлын гишүүд, тэдний залгамж халаа Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлага, ажилтнууд Та бүхэндээ парламентат ёсыг төлөвшүүлэхэд оруулсан хувь нэмэрт тань гүн талархал илэрхийлж байна аа.

Өнгөрсөн 7 дугаар сард Швейцарын Холбооны Улсад зохион байгуулсан 180 орны төлөөлөл бүхий Парламентын дарга нарын дэлхийн VI бага хуралд Монгол Улсаа төлөөлөн оролцож, манай улсын парламентын төлөөллийн ахиц, шинэ стратеги, хэтийн зорилго, хамтын ажиллагааны талаар илтгэл хэлэлцүүлэхэд монголчууд бидний амжилтыг олон улс өндрөөр үнэлж, хурлын үеэр манай улсын

туршлагаас судлах хүсэлтээ илэрхийлж байсныг энд тэмдэглэн хэлье.

Дэлхий нийтээр ардчиллын үнэт зүйлсийг тэмдэглэн өнгөрүүлдэг энэ өдөр Монгол Улсын Их Хурлын намрын чуулганы нээлт тохиож байгаа нь онцгой бэлгэ дэмбэрэлтэй юм. Ардчиллаа хамгаалах, бэхжүүлэх, олон ургалч үзэл санааг түгээн дэлгэрүүлэхийг ард иргэддээ сануулж, тэдний итгэл, хүсэл зорилгыг төлөөлөн сууж буй Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ болон Монголын ард түмэндээ, хүрэлцэн ирсэн хүндэт зочдодоо олон улсын ардчиллын өдрийн мэндийг хүргэе.

Эрхэм хүндэт ард иргэд ээ,

Энэ удаагийн намрын ээлжит чуулган хэд хэдэн онцлогтой эхэлж байна. Хууль тогтоох ажиллагаанд чухал хамааралтай Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 8 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн.

Түүнчлэн Улсын Их Хурал шинэ бүтцээр ажиллаж эхэлж байна. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах, гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээг нэгтгэн 11 байсан Байнгын хорооны тоог цөөлж 8 болгосон. Ард түмнээс эхтэй парламент тэднийхээ дуу хоолойг байнга сонсож, нээлттэй, эргэх холбоотой стратеги бодлого биеллээ олох ёстой.

Бид эдийн засаг, бизнесийн мега төслүүдийг хөдөлгөхөөс гадна “Хүн төвт” стратегиа өнгөрсөн намрын чуулганаар батлан хэлэлцсэн. Энэ стратегийнхаа дагуу Улсын Их Хуралд Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо, Өргөдлийн байнгын хороо байгуулагдлаа. Улсын Их Хурлын энэхүү шинэ бүтэц, механизмыг хэвшүүлэх, үр дүн гаргаж ажиллахад Байнгын болон дэд хорооны дарга, гишүүд идэвх, санаачилгатай ажиллана гэдэгт итгэлтэй байна.

Эрхэм хууль тогтоогчид оо,

Өнөөдөр иргэд, аж ахуйн нэгжүүд татвар, нийгмийн даатгалын дарамтыг бууруулж, төрийн бизнесийг биш харин хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмждэг хууль, эрх зүйн орчныг хүсэж байна. Энэ бол олон хэвшил бүхий эдийн засагтай байх, өмчлөгчийн эрхийг хамгаалах Үндсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэхийг хүссэн ард түмний хүсэл юм.

Монгол Улсын нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоо нь хуучин нийгмийн бүтэц дээрээ гацжээ. Энэ тогтолцоо ажлын байрыг нэмэгдүүлэх, эдийн засгийг тэлэхэд тус нэмэр болж чадахгүй, далд хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг өдөөж байна. Нийгмийн даатгал нь ажил хийж, ажлын байр бий болгож байгаа хүнд шийтгэл мэт болж “нурууг нь” авч байна. Тиймээс хуучирсан тогтолцооны зарчмыг үндсээр нь халж, нийгмийн даатгалын тогтолцоог иргэн бүр өөрийн нэрийн дансаа удирдах, хөдөлмөрийн зах зээлийг хөхиүлэн дэмжих, тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр шинэчлэх учиртай. Энэ шинэчлэл нийгмийн даатгалын сангийн алдагдал, буруу удирдлага, хулгай луйврын ул мөрийг нөхөхөд чиглэх ёсгүй. Монгол Улсын иргэн бүр өөрийн хуримтлалынхаа жинхэнэ эзэн байх зарчмыг гол цөмөө болгож, бодитой шинэчлэх хуулийн төслийг Засгийн газар, холбогдох яам боловсруулж өргөн мэдүүлэх шаардлагатайг цохон тэмдэглэе.

Иргэдийн хүсэн хүлээж буй татварын бодлогын хувьд төсвийн орлого,

зарлагын бүтцийн асуудлыг бүх талаас нь уялдаатай авч үзэх шаардлагатай. Татвар нэг талаас нийгэм, эдийн засгийн хөтөлбөрийг санхүүжүүлэх төсвийн орлого бүрдүүлэхэд, нөгөө талаас олон хэвшил бүхий эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чиглэх ёстойг Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага онцолдог. Гэтэл манай улсын татварын бодлого төсвийн орлого бүрдүүлэх чиг үүрэгт хэт анхаарсны улмаас 2024 онд гэхэд улсын төсвийн орлогын 92 хувийг зөвхөн татварын орлогоос бүрдүүлсэн. Тэгвэл энэ ачааллыг төрийн өмчит компаниудын үр өгөөжийг сайжруулснаар бодитой багасгах боломж байсаар байна.

Татварын хэт ачаалал, бүтээмж, өсөлт, хөгжлийн дайсан болж байна. Төр дарамтыг биш, боломжийг бий болгох ёстой. Тиймээс татварын хуулиудад “гар хүрэх төдий” өөрчлөлт хийх биш, татварын ачааллыг бодитоор бууруулж жинхэнэ утгаар “нурууг тэнийлгэх” шинэчлэл хийх цаг нь болжээ. Татвар бууруулах тохиолдолд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын зэрэг нийгмийн шинжтэй өсөн нэмэгдэж буй зардлыг санхүүжүүлэх нэмэлт эх үүсвэр бий болгох шаардлага үүсэх нь тодорхой. Үүний тулд

нэгд, төсвийн орлого бүрдүүлэх тогтолцоо, бүтцийг өөрчлөх эрх зүйн орчин бүрдүүлэх;

хоёрт, төрийн албаны зардлыг бууруулах, үр ашигтай, бүтээмжтэй загварыг бий болгох шаардлагатай.

Төрийн өмчит компаниудын ашиг, үр өгөөжийг нэмэгдүүлж улсын төсөвт төвлөрүүлэх хэрэгтэй. Өдгөө төрийн өмчит болон өмчийн оролцоотой компаниудын нийт хөрөнгө нь 59.4 их наяд төгрөгт хүрч, ДНБ-ийн 74.3 хувьтай тэнцэж байгаа боловч төсөвт төвлөрүүлэх орлого, ногдол ашиг, өгөөж нь үлэмж доогуур явж ирлээ.

Тодруулбал, 2024 онд төрийн өмчит компанийн 33 хувь нь алдагдалтай ажиллаж, ашигтай ажилласан хэсгийн 90 хувийг “Эрдэнэс Монгол Нэгдэл” дангаар бүрдүүлжээ. Төрийн өмчит компаниудын өр төлбөр нь 22.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

Орон нутагт энэ байдал дээрдэх зүйлгүй. Орон нутгийн өмчийн 350 аж ахуйн нэгжийн зөвхөн 30 хувь нь 388 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 2023 онд ердөө 1 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан. Энэ байдал цааш үргэлжлэх ёсгүй.

Өнөөдөр төрийн өмчит 107 компанийг 9 яам, агентлаг харьяалан удирдаж компаниудын үр ашиг, өгөөжид хяналт, гүйцэтгэлийг шаарддаг, хариуцлага тооцдог мэргэжлийн удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн бүрэлдээгүй байна. Хувийн хэвшлийн хийж чаддаг бизнесийн орчинд төр аж ахуй нэгжүүдтэй өрсөлддөг байж болохгүй. Энэ хүрээнд Улсын Их Хурлын намрын чуулганаар төрийн өмчийн бодлогын шинэчлэл, хувийн хэвшлийн бизнесийн орчныг сайжруулах санаачилгыг дэмжин ажиллана.

Төрд нийгмийн хариуцлагын хүрээнд зайлшгүй үүрч явах ёстой төрийн өмчит компанийн засаглалыг шинэ шатанд гаргаж, нээлттэй, ил тод байдлыг бүрдүүлэхийн тулд улс төрийн нөлөөллөөс ангид, зөвхөн мэргэжлийн ур чадвар, туршлага дээр тулгуурласан менежерүүдээр удирдуулах шаардлагатай. Эдгээр бодлогын шинэчлэл хууль тогтоомжоор дамжин хэрэгжих учиртай.

Иймд Улсын Их Хуралд хэлэлцүүлгийн шатанд байгаа “Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай” болон “Нийтийн өмчийн тухай” хуулийн төслийг нягт хэлэлцэж, цогц шийдэлд хүрэх шаардлагатайг онцлон тэмдэглэн хэлье.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан эрчим хүчний салбарын эрх зүйн орчны болон энэ салбар дахь төрийн өмчит хуулийн этгээдийн шинэчлэл нэн яаралтай хийгдэх учиртай. Тиймээс өргөн мэдүүлсэн Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэхдээ зөвхөн давуу талыг бус, сөрөг үр дагаврыг ч олон талаас нь нягтлан шийдвэрлэхийг анхааруулъя. Мөн энэ салбарын шинэчлэлийн асуудлаар судалгаа, санал, дүгнэлт гаргахаар байгуулагдсан ажлын хэсэг холбогдох хууль тогтоомжийн төслүүдээ цаг алдалгүй өргөн мэдүүлэх нь зүйтэй.

Төрийн байгууллагуудын ажил давхардал ихтэй, хөдөлбөл л зөвшөөрөл, бүртгэл нэхэж, байгууллагын журам гэгчээр хүнд суртал үүсгэж байгаа нь үнэн. Бид төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулна, шуурхай болгоно гэх мөртөө иргэд, аж ахуй нэгждээ ээлгүй, хэтэрхий хүнд сурталтай байсаар байна. Өнөөдөр нэг үйлдвэр барихад “есөн эрүү” тулгах мэт бичиг цаасны олон шат дамжлагатай байгаа нь бидний бодож санасан зүйлс үнэндээ ажил хэрэг болохгүй байгааг харуулж байна.

Тиймээс процессын дахин инженерчлэлийг бүх салбар, шатанд хэрэгжүүлэх ёстой. Энэ бодлогын хүрээнд хаврын чуулганаар “Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх ажлыг эрчимжүүлэх талаар чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2025 оны 78 дугаар тогтоол батлагдсан. Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэлийг ганц нэг салбар төдийгөөр оромдож хийх биш, төрийн байгууллагууд хоорондын болон салбар дундын уялдаа холбоог углуургаар нь харж, системээр нь авч үзэх ёстойг тал талдаа бодолцож, хурдтай, санаачилгатай ажиллах хэрэгтэй.

Цаашид Төрийн байгуулалтын байнгын хороо энэ тогтоолын биелэлтэд тавих хяналтаа эрчимжүүлж, үр дүнг олон нийтэд улирал тутамд тайлагнаж ажиллахыг сануулъя. Мөн холбогдох бусад Байнгын хороо салбар бүр дэх процессын дахин инженерчлэлийг тууштай дэмжиж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ёстой.

Эрхэм гишүүд ээ,

Монголын ирээдүй бол бидний үр хүүхдүүд. Гэтэл багшгүй, сургуульгүй, хоолгүй хүүхдүүдээс бид ирээдүйд юуг хүлээх вэ. Цаашид бид хүүхдүүдийнхээ ирээдүй, улс орны хөгжилд хамаарах боловсролын асуудлуудыг бүхэлд нь харж, тогтолцоо, төсвийн шинэчлэл хийх шаардлагатай байна. Багшийн хүрэлцээ, сургалтын чанар, ажлын таатай орчин, сургуулийн дэд бүтэц, үдийн хоолны хөтөлбөрийг нэгэн зэрэг, уялдаа холбоотойгоор шийдвэрлэх нь өнөөдрийн бидний үүрэг юм аа.

Сүүлийн 10 жилд сурагчдын тоо 43.7 хувиар өссөн бол багшийн тоо ердөө 24.9 хувиар нэмэгдсэн байна. Багш ажлын байраа орхих байдал буурахгүй байна. 2016 онд шинэ багш нарын 4.3 хувь ажлаа орхисон бол 2022 онд энэ үзүүлэлт 12.7 хувьд хүрч нэмэгдсэн байна. Хими, биологи, англи хэл, мэдээллийн технологийн багш нар илүү өндөр үнэлэмжтэй бусад салбарт шилжиж байгаа нь нөхцөлийг улам бүр хүндрүүлж байна. Үүний улмаас өнөөдөр төрийн өмчит сургууль, цэцэрлэгт 5 мянга

гаруй багшийн бодит дутагдал үүссэн байна. Энэ тоо ойрын 3 жилд өсөж, сургуульд 14 мянган багшийн дутагдал үүсэхээр байна. Иймд багшийн цалин урамшууллыг уян хатан болгож, ажлын ачааллыг шударгаар үнэлэх, орчин нөхцөлийг шинэчлэх, ил тод, шударга үнэлгээний тогтолцоо бий болгох шаардлагатай байна.

Өнөөдөр 1 ангид 70 хүүхэд сурч байгааг хараад төсөв байхгүй гэж шалтаглах эрх бидэнд байхгүй. Нийт хүүхдүүдийн маань талаас илүү хувь нь 1800-аас дээш сурагчтай, даац хэтэрсэн сургуульд сурч байна. Улсын хэмжээнд 124 сургууль хэт өндөр ачаалалтай байна. Анги дүүргэлтийг 40 хүүхдээс хэтрүүлэхгүйн тулд нийт 108 сургууль шинээр барих шаардлагатай. Үүний өртөг нь 1.6 их наяд төгрөг болно. Асуудлыг ирэх 3 жилдээ үе шаттай шийдэхэд жил бүр 36 сургууль, 32 цэцэрлэг барих төсөв зайлшгүй хэрэгтэй байна.

Монголын ирээдүй болсон хүүхдүүд маань эрдэм номтой бөгөөд эрүүл байх ёстой. Монгол хүүхдүүдийн дунд Д витамин дутагдал өндөр, чихэрлэг хүнсний хэрэглээ их, сүү цагаан идээний хэрэглээ хангалтгүй байгаа нь тэдний эрүүл мэндэд ноцтой аюул учруулж байна. Дэлхийн 160 гаруй улс орны туршлагаас харахад, сургуулийн бүх ангийг үдийн хоолны хөтөлбөрт хамруулах нь хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, улмаар сурлагын ахиц гаргах үр дүнтэй арга гэдэг нь нотлогдсон.

Манай улс одоогоор зөвхөн бага ангийг үдийн хоол хөтөлбөрт хамруулж байгаа ч цаашид дунд, ахлах ангийн хүүхдүүдийг хамруулах шаардлагатай байна. Үүнд жил бүр ойролцоогоор 200 гаруй тэрбум төгрөг хэрэгтэй бөгөөд үр өгөөж нь мөнгөөр хэмжигдэшгүй гэдгийг та бүхэн ойлгож байгаа байх аа.

Улсын Их Хурлаас батлагдсан үдийн хоолны төсөв хүүхдэд бүрэн зориулагдаж байгаа эсэх, хоолны шим тэжээл, орц, хүртээмж, нийлүүлэлтийн дэд бүтэц зэргийг гишүүд болон холбогдох Байнгын хороо газар дээр нь дээр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийн талаар бодит дүгнэлт гаргах хэрэгтэй. Үдийн хоолыг дунд, ахлах ангиудад өргөжүүлэх асуудлыг судлах чиглэлээр шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын даргын хувьд санаачлан хэрэгжүүлнэ. Цаашид энэ мэтчилэн Улсын Их Хурал баталсан хууль тогтоомжуудын хэрэгжилтэд нэг бүрчлэн хяналт тавьдаг байх жишигт анхаарч ажиллана.

Хууль тогтоомжийн тухай хуулиар аливаа хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд нэгдсэн байдлаар байршуулахаар болсон. Засгийн газар, Улсын Их Хурлын Тамгын газар, харьяа байгууллагууд энэ шинэ зохицуулалтыг баримталж ажиллах ёстой.

Өнөөдөр боловсролоос гадна Монгол хүний амьдралын чанарт чухал нөлөөлөх хүчин зүйл бол эрүүл мэнд юм. Иргэдийн халааснаас гарах эрүүл мэндийн зардал нэмэгдэж амьдралын чанарт сөргөөр нөлөөлж байна. Өмнөх парламентын үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжүүлэх хууль, бодлогын үндэс тавигдсан. Үүний үр дүнд урьдчилан сэргийлэх үзлэг өргөжиж, хөнгөлөлттэй эмийн хүртээмж сайжирч, салбарын ажилтнуудын нийгмийн асуудалд тодорхой ахиц гарсан байна. Гэвч бидэнд дутуу харсан зүйл байна. Тухайн шинэчлэл эмнэлгийн санхүүжилт, даатгал, цахимжилтад төвлөрсөн ч тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, хяналтын тогтолцооны шинэчлэл орхигдсон байна.

Өнөөдөр эмнэлгүүдийн санхүүжилт нь тоо хэмжээнд суурилж, чанартай

үйлчилгээ үзүүлэх бус, илүү олон тохиолдол бүртгэх сонирхлыг бий болгожээ. Судалгаагаар хэвтэн эмчлүүлж буй тохиолдлын 30–40 хувь нь үнэндээ амбулаторийн түвшинд шийдэгдэж болох ажээ. Эмнэлгийн зардал байнга өсөж байна. 2020 онд Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал 500 орчим тэрбум төгрөг байсан бол 2024 онд 1.9 их наяд төгрөг болж бараг 5 дахин өссөн ч иргэдийн сэтгэл ханамж, үйлчилгээний чанар тэр хэрээр нэмэгдсэнгүй.

Олон улсын туршлагаас харахад, “бага зардлаар ихийг хийх” зарчим баримтлан урьдчилан сэргийлэх, анхан шатны тусламжид гол санхүүжилт чиглэж байна. Харин манай улсад анхан шатны тусламж нийт үйлчилгээний тал хувийг эзэлдэг мөртөө санхүүжилтийн 20 хүрэхгүй хувь ногдож байгаа нь том зөрүү юм.

Бид үл хязгаарлагдах хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр санхүүжүүлэхдээ:

нэгд, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын тооцоололд шинжлэх ухаанч, мэргэжлийн хандлага нэвтрүүлэх, оновчтой төлөвлөх мэргэшсэн институтийг бий болгох;

хоёрт, чанар, нэхэмжлэлийн хяналтын хараат бус тогтолцоог хөгжүүлэх;

гуравт, анхан шатны тусламж, урьдчилан сэргийлэх үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх нэн шаардлагатай байна. Энэ шинэчлэлийг хийхдээ Улсын Их Хуралд эрүүл мэндийн асуудлаар байгуулагдсан гурван ажлын хэсгийн судалгаа, санал, дүгнэлтийг харгалзан Засгийн газар, салбарын яам, парламент, оролцогч талууд хамтран ажиллах нь зүйтэй.

Эрхэм гишүүд ээ,

Хуулийг ерөнхийлөн боловсруулж, амин чухал асуудлыг нь журам руу “чулуудаж” байсан, товчхон хууль гаргах залхуу арга барил, авлига, дур зоргыг цэцэглүүлж, амьдралд саад тотгор үүсгэж байна. Аж ахуйн нэгж, ард иргэдийн амьдралыг зохицуулж байгаа журмуудыг ямар нэг баримтлах зарчимгүй, хязгаарлагдах цар хүрээгүй үзэмж, дур зоргоор батлах явдал газар аваад байсан. Үүнийг цэгцлэхээр Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хаврын чуулганаар баталсан. Энэ хуультай хамт баталсан “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа бүх хуулийг Хууль тогтоомжийн тухай хуульд нийцүүлэхийг даалгаж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан. Энэ ажлын хүрээнд журмын тоо цөөрч, хуульд тусгагдах ёстой боловч журамд орсон байгаа заалтууд цэгцэрнэ. Парламент хэм хэмжээ тогтоох эрхээ шилжүүлэх явдал ямар нэг зарчим, шалгуур, зохицуулалтгүй өрнөж байсан бол одоо хуулийн хязгаар, хүний эрхийн зарчимд нийцэж явагдах юм. Эдгээр бодлого, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлснээр нь хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална гэсэн Үндсэн хуулийн заалт бүрэн утгаар биеллээ олно.

Цаашид өргөн мэдүүлэх хуулийн төслүүдэд тавигдах шаардлага өндөрссөнтэй холбогдуулан Тамгын газар хуулийн төслийн бүрдлийг нягтлахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийг чанд баримталж ажиллахыг даалгаж байна.

Эрхэм нөхөд өө,

Энэ чуулганаас эхлэн төсвийн төслийг 5 үе шаттай шинэ дэгээр хэлэлцэнэ. Мөн төсвийн төслийг буцаах харилцаа, төсвийн хууль тогтоомжид тавих Ерөнхийлөгчийн хоригийн асуудал нарийвчилсан зохицуулалтгүй байсан бол одоо хуульд илүү тодорхой болоод байна. Тиймээс эрх зүйн шинэ зохицуулалтын дагуу төсөв хэлэлцэн батлах гишүүд, Та бидний үүрэг хариуцлага нэмэгдэж байна.

Улс орныхоо төсөв батлах, хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд гишүүд төсөв санхүүгийн гүнзгий мэдлэгтэй байх, санхүүгийн тайлан, аудитын үр дүнг уншиж дүгнэх чадвараа хөгжүүлэх нийгмийн шаардлагыг хангаж ажиллах ёстойг онцлон анхааруулъя.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд байгаа Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа Засгийн газар иргэдийн оролцоог бага зардлаар, өргөн хүрээнд хангаж E-Mongolia систем ашигласан нь сайшаалтай байна. Санал асуулгаар иргэд 2026 онд хамгийн их анхаарал хандуулж төсөв зарцуулах ёстой салбарыг эрүүл мэнд, боловсролын салбар гэж үзжээ. Гэвч өргөн мэдүүлсэн төсөвт боловсролын салбарт зарцуулах төсөв өмнөх оныхоос нэмэгдээгүй орж ирсэн нь бидний хүүхдүүдийн сурч боловсрох эрхэд тулгараад байгаа дээр дурдсан бэрхшээлүүдийг шийдэхэд дорвитой нэмэр болж чадахааргүй байна.

Түүнчлэн өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь өмнөх жилийн зарчмаас өөр буюу 1.3 их наяд төгрөгийн алдагдалтай байгааг Улсын Их Хурлын гишүүд анхааралдаа авч, сайтар тунгааж үзэхийг хүсье. Ингэхдээ эдийн засгийн идэвхжил саарч байгаа ийм үед, одоо байгаа дотоод эрэлтийг хадгалахын тулд хэмнэлтийн бодлогын эрэмбэ, дэс дарааллыг зохистой хийх нь зүйтэй.

Наадмын дараах намрын их ажил улс даяар өрнөж, айл өрх, албан газар бүр өвөлжилтийн бэлтгэл базааж байна. Энэ жил нийт нутгийн 40 гаруй хувь гантай болон гандуу зуслаа. Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Өвөрхангайн зарим нутаг болон Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймаг зэрэг газар тариалангийн гол бүсийн зарим хэсэгт зуншлага тааруу өнжлөө. Зуншлагын нөхцөл байдлаас улбаалан өвөлжилт, хаваржилт анхаарал татаж байна.

Засгийн газар ирж буй цагийг угтан илүү өндөр сэрэмжтэй байж, өвөлжилтийн бэлтгэлийг цаг алдалгүй, чанартай хангах шаардлагатай байна. Эрчим хүчний салбарт үүсээд буй нөхцөл байдал нь ирж буй өвөл хатуухан сорилт болохыг анхааруулж байна. Иймд салбар бүр дор бүрнээ зохион байгуулалттай, хариуцлагатай ажиллахыг сануулъя.

Эх орон, ард түмнийхээ язгуур эрх ашигт үйлчилж, иргэд, сонгогчдынхоо итгэл хүндлэлийг биелүүлэхийн төлөө эрхэм гишүүд Та бүхэн эрдэм мэдлэг, арга туршлага, ур ухаанаа дайчлан хамтран ажиллаж, 2025 оны намрын чуулганы төлөвлөсөн ажлаа нэр төртэй хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Монгол түмний хийморь сүлд өөдөө байж, эх орон маань цэцэглэн хөгжих болтугай.

Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы нээлтийн үйл ажиллагаа өндөрлөлөө. Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан 14 цаг эхэлнэ.

ЗАВСАРЛАГА.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын гишүүдийн ирц 118 гишүүн бүртгэгдэж, 93,7%-тай байна. 2025 оны намрын ээлжит чуулганы 9 дүгээр сарын 15-ны өдрийн үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

2 дугаарт Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 95.3-д нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 95.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын 5 өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж заасан.

Нийтийн өргөдлийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын иргэн Отгоны Батхүү нийтийн ашиг сонирхлыг хөндсөн үл хөдлөх хөрөнгө борлуулахад төлдөг 2%-ийн татварыг хүчингүй болгох асуудлыг хуулийн төсөл санаачлах нийтийн өргөдөл ирүүлснийг Улсын Их Хурлын нийтийн өргөдөл, гомдлын системд 2025 оны 8 дугаар сарын 15-ны өдөр нийтэлсэн. Уг өргөдөл 2025 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр Монгол Улсын 18 насанд хүрсэн 100,176 иргэний санал авсан тул нийтийн өргөдөлд дурдсан асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхээр Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний дагуу Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороонд хуваарилсан.

Төсвийн байнгын хороо болон Өргөдлийн байнгын хороо иргэдийн гаргасан өргөдөлд дурдсан асуудлыг хуульд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх илтгэлийг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэндээ юуны өмнө Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент үүсгэн байгуулагдсаны түүхт 35 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хүн төрөлхтнийг нөмөрсөн цар тахлын үр дагавар, хар сүүдэр бүрэн арилаагүй, дэлхийн дэг журам өөрчлөгдөж, цаг төр, үймээнтэй, ярагдсан төмөр хөшиг ахин татагдсан, хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан ган зуд, гамшиг осол нүүрлэсэн цаг үеийн уур амьсгал дор та бид улс орон ард түмнийхээ ирэх жилийн аж амьдралыг төсөөлөн төлөвлөхөөр цуглараад байна. Дээрх шалтгаан нөхцөлүүдээс шалтгаалсан үнийн өсөлт өрх айл, хүн бүрийн халаасыг тэмтэрсэн улс орон бүхний үүц нөөцийг дундалсан, үндэсний аюулгүй байдал үндэстнүүдийн аюултай байдалд заналхийлсэн тодорхойгүй урьдчилан таамаглахад хэцүү цаг дор Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг та бүхэнд өргөн танилцуулж байна.

Өнөөдөр ч дэлхий дахинд геополитикийн хурцадмал байдал, худалдаа тарифын зөрчил үргэлжилж энэ бүх эрсдэл Монгол Улсын эдийн засгийг хүчтэй сорьж байна. Нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд манай улсын эдийн засгийн аюулгүй байдал, хамаарал туйлын эмзэг байгааг онцлон тэмдэглэж байгаа юм.

Монгол Улсын гадаад худалдааны 70 гаруй хувь, экспортын 90 гаруй хувь 1 улсаас хамааралтай. Эрчим хүч 24%, түлш шатахуун 100% гадаад улсаас хамааралтай, гадаад өрийн хэмжээ ДНБ-ий 160 гаруй хувьд хүрсэн. Эдийн засгийн төрөлжилтийн индексээр Монгол Улс дэлхийн 145 орноос 139-д бичигдсэн. Ийм бодит байдал, дүр зурагтай байна. Ийм тоо баримтыг олныг ярьж болно. Энэ бол зүгээр нэг тоо бус Монгол Улсын эдийн засгийн эмзэг байдлын бодит дүр зураг юм.

Ийм учраас ирэх жилүүдийн бидний эдийн засгийн төсөөлөл 5 жилийн үндсэн чиглэл боловсруулж байгаа чиг хандлага, зорилго бол эдийн засгийн аюулгүй байдлаа эрс сайжруулж, эмзэг байдлаа бууруулахын тулд эдийн засгийн бодлогын бүтцийн өөрчлөлтийн бодлогыг үргэлжлүүлж, эдийн засгаа төрөлжүүлэх, өргөжүүлэх эрс шинэчлэлийг эхлүүлэх шаардлагатай байгаа. Үүнтэй уялдуулж бид ирэх онуудын төсвийн төсөөллөөс байнга тодотгож өөрчлөгдөж байх шаардлага ч гарахыг үгүйсгэхгүй.

2024 оноос нүүрсний үнэ унаж, экспорт хумигдаж, төсвийн орлого тасарч, валютын нөөц багасаж, төгрөгийн ханш сулран, үнийн өсөлт эрчимжиж, эдийн засгийн өсөлт эхний улиралд 2,4 хувьд хүрч буурч 2 дахин буурсныг та бүхэн санаж байгаа. Хэрэв энэ нөхцөл байдал цаашид хэвээр үргэлжилбэл төсвийн алдагдал нэмэгдэж, инфляц 15 хувьд хүрэх, валютын ханш долларын ханш 4 мянгад хүрч, төсвийн орлого 3,3 их наядаар буурах, төлбөрийн тэнцлийн алдагдал 1 тэрбум долларт хүрэх иргэдийн амьжиргаанд үнийн өсөлт ихээхэн дарамт учруулах ийм бодит эрсдэл нүүрлэсэн байсан. Ийм нөхцөлд Засгийн газар цаг алдалгүй, яаралтайгаар бүсээ чангалж, 2025 оны төсөвт хэмнэлтийн тодотгол хийж, түүхэндээ анх удаа 2,2 их наяд төгрөгөөр төсвийн зарлагыг бууруулсан. Үр дүнд нь зах зээлийн хүлээлт тогтворжиж, инфляц ханшийн савлагаа багасаж, инфляцын дарамт буурсан. 2025 оны эхний улиралд 2,4% хүртэл унасан өсөлт 2 дугаар улиралд 5,6%

болж сэргэлээ. Экспорт сэргэж, валютын нөөц 5 тэрбум доллараас доош орохоор байсан бол өнөөдөр 5,7 тэрбум долларт хүрч валютын нөөц нэмэгдлээ.

Монгол Улсын валютын төлбөрийн тэнцэл буюу валютын экспорт, импортын бодит урсгал 7, 8 дугаар сард төлбөрийн тэнцэл дараалан ашигтай гарлаа.

Эрхэм гишүүд ээ, тоо худал хэлдэггүй. Энэ бол төсвөө тодотгож, хэмнэж чадсан та бидний хамтын хүчин чармайлтын бодит үр дүн юм.

Эрхэм гишүүд ээ,

Төсвийн бодлогын тулгуур зарчим бол тоо бус чанар, мөнгө бус итгэл, зарлага бус өгөөж байх ёстой. Тиймээс энэ удаагийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг иргэдийн хүсэл зорилго, тэдний үнэлгээ, санал зөвлөмжид тулгуурлан боловсрууллаа. Цаашдаа төсвийн шинэчлэл бол иргэдийн оролцоотой, иргэдийн хяналттай, иргэдээс үнэлдэг, ийм нээлттэй ил тодын зарчимд тулгуурласан төсвийн үр ашгийг нэмэгдүүлсэн цогц шинэчлэл байхаар төлөвлөж, төсвөө бид боловсруулсан.

Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулахдаа бид дараах суурь зарчмуудыг баримталлаа.

Эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн орлого, зардлыг бууруулах, өрийн хэмжээг бууруулах, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгах, иргэн, хувийн хэвшлийг дэмжсэн татварын шинэчлэлийг эхлүүлэх, татвар төлөгчдийн 1 төгрөг бүрийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, энэ бүхнийг нийгмийн зөвшилцөл, иргэдийн оролцоог хангах, татвар төлөгчдийн оролцоог хангах замаар шийдвэрлэх зарчмыг баримталлаа.

Эдгээр зарчмын хүрээнд хувийн хэвшлийг дэмжсэн хүний хөгжилд чиглэсэн дунд хугацааны төсвийн бодлогыг тодорхойлсон болно. Энэ хуулийн төсөлд макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийг дараах байдлаар тооцлоо.

1 дүгээрт, эдийн засгийн өсөлтийг 2026 онд 5,7%-аар, 2027 онд 6,3%-аар, 2028 онд 6,5% байна гэж төсөөллөө. 2025 оны эхний улиралд эдийн засгийн өсөлт 2,4% хүртэл буурсан ч хагас жилийн дүнгээр 5,6 хувь болж сэргэсэн. Үүнд Хөдөө аж ахуйн салбар 35%-ийн өсөлттэй гарсан нь гол дэмжлэг болсон. Үүн дотроо боловсруулах үйлдвэрийн салбар 68%-ийн өсөлттэй эдийн засгийн өсөлтөд бодитой үр дүн оруулсныг онцлон тэмдэглэж байна.

Харин бол уурхайн бүтээгдэхүүний үнийн уналт экспортын бууралтын улмаас 2026 оны төсөөллийг өмнөх 6%-аас бууруулж, 5,7% болгон тооцлоо. Харин эдийн засгийн өсөлтийг тогтвортой 6%-аас дээш түвшинд хадгалах зорилтын хүрээнд 2027 онд 6,3%, 2028 онд 6,5% өсгөхөөр тооцлоо.

Дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмжих гол салбарууд бол хүнд аж үйлдвэрийн салбар. Ган, зэс, төмрийн хүдэр, нүүрс баяжуулах шинэ төслүүдийг бид бодитой хэрэгжүүлж эхэлсэн. Эрдэнэтийн зэсийг эцсийн бүтээгдэхүүн болгож боловсруулах, паркийн дэд бүтцийг Эрдэнэт үйлдвэр амжилттай бүрдүүлсэн. Саяхан бид ТЭЗҮ-ийг боловсруулахад шаардлагатай Эрдэс баялгийн зөвлөлөөр батлуулахаар Оюутны шинэ ордыг 357 сая тонны ордтой шинэ нөөцийн Эрдэс

баялгийн зөвлөлийн дүгнэлтийг бэлэн болгож яаманд, Эрдэс баялгийн зөвлөлд хүргүүлсэн. Катодын зэсийн үйлдвэрийн ТЭЗҮ-г баталлаа. 10 дугаар сард хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар төлөвлөж байна. Жилд 560 мянган тонн баяжмал боловсруулах, 125 мянган тонн катодын зэс үйлдвэрлэх ТЭЗҮ-ийг бэлэн болголоо. Паркт зэс, кабель, хавтас хоолой, нано нунтаг зэрэг өндөр нэмүү өртөгтэй үйлдвэрлэл үе шаттай хөгжинө. Ийм Эрдэнэтийн паркийн дэд бүтцийг үндсэндээ байгуулах ажил хэрэгжиж эхэлсэн гэхэд болно.

Ингээд ган төмөр зэсийн үйлдвэр бол орчин үеийн хөгжлийн гүүр тулгуур багана болсон. Ийм учраас бид 2027 он гэхэд эдийн засгийн бодит өсөлтөд ихээхэн хувь нэмэр оруулах тооцоололтой. 2026 оны хавар барилгыг эхлүүлж, ирэх хавар бид барилгын ажлыг эхлүүлж, 2028 оны 3 дугаар улиралд энэ зэсийн үйлдвэр зэс, катодын үйлдвэрийн цогцолборыг ашиглалтад оруулахаар төлөвлөсөн ТЭЗҮ-ийг боловсруулж, тендер гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг эхлүүлээд байна.

Дотооддоо зэсээ боловсруулах стратеги 30 гаруй жилийн хүсэл мөрөөдөл цаасан дээр байсныг бодит ажил хэрэг болгохоор зэсийн нөөцийг нэмэгдүүлсэн. Оюутын ордоо баталгаажуулах энэ чиглэлээр бодитой ТЭЗҮ-ийн үнэлгээ, ажлын даалгаврын ажлыг бэлэн болгож ажиллалаа. Газар дээр нь.

Дархан, Сэлэнгийн гангийн цогцолбор, кокс, эрчим хүчний үйлдвэр, цахилгаан станц, төмрийн баяжуулах, ган хайлуулах, тээвэр логиستيкийн төв зэрэг цогц бүтцийг 2026 оны 1 дүгээр улиралд эхлүүлж, 2027 онд ашиглалтад оруулахаар ажлын хэсэг байгуулж, ажилдаа ТЭЗҮ болон холбогдох баримт бичгийг боловсруулж эхлээд байна.

Нүүрс химийн үйлдвэр нялх Чойрын бүсийн 9 тэрбум тонны хүрэн нүүрсний нөөцөд тулгуурлан нүүрс пирализын үйлдвэрийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөлт дууссан. Энэ ондоо гүйцэтгэгчийг шалгаруулж, ирэх онд барилгыг ажлыг эхлүүлээд, 2027 онд бүрэн ашиглалтад оруулахаар төсөл төлөвлөгөөг баталлаа.

Дотоодын хөх нүүрсний хангалтыг бий болгож, агаарын бохирдлыг бууруулах, улмаар ган, нүүрс, химийн салбарын суурь болгоно. Нефтийн үйлдвэрийг 2027 оны 3 дугаар улиралд ашиглалтад оруулж, түлш шатахууны импортын хамаарлын бууруулах, газын хоолойн бүтээн байгуулалтын ажлыг ирэх жилээс эхлүүлэх, эрчим хүчний салбарын хувийн хөрөнгө оруулалтуудыг идэвхжүүлэлт чиглэлийг барьж, холбогдох ажлын хэсгүүдийг байгуулан ажилдаа орсныг та бүхэндээ танилцуулахад таатай байна.

Тээвэр логиستيкийн хувьд хил дамнасан төмөр зам, ухаалаг боомт, цахим гаалийн төслүүд амжилттай хэрэгжиж эхлээд байна. Боловсруулах үйлдвэрийн салбар эрчимтэй өсөж байгааг та бүхэнд өмнө нь мэдээлсэн. Одоо энэ хүрээнд Цагаан алт, Хүнсний хувьсгал, Атар 4 дүгээр аяны хүрээнд боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эдийн засгийн чөлөөт худалдааны хэлэлцээрт тулгуурлан Евро-Азийн зах зээл буюу 184 сая хүн амтай 2,4 их наяд триллион долларын зах зээлд нэвтрэх боломжийг ирэх жилээс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна. Ингэж байж бид эдийн засгаа төрөлжүүлэх, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортыг дэмжсэн цогц үйлдвэрлэлийг дэмжиж хэрэгжүүлнэ.

Шинжлэх ухаан, инновац, дэвшилтэт технологийн нэвтрэлтийг бүх салбарт нэвтрүүлж, дижитал пост буюу цахимыг энэ тэргүүнд тавьсан цогц хөтөлбөрийг

холбогдох яамд яам дундын хөтөлбөр болгон хэрэгжүүлж эхэлж байна. Энэ бүхэн маань бол ирэх 3 жилд бидний эдийн засгийн өсөлтийг эрс эрчимжүүлэх бодит ажил хэрэг болж хэрэгжинэ. Энэ бүхэн бол эдийн засгийн өсөлтийн суурь нөхцөлүүдийг бүрдүүлнэ.

2 дугаарт, инфляцын төсөөлөл инфляц 2025 оны 8 дугаар сард 8,8%-тай байгаа ч 2026 оны 7%, 2027 6%, 2028 онд 5% болгон бууруулна гэж тооцлоо. Энэ зорилгод хүрэхийн тулд бид 2 чиглэлд онцгой анхаарна.

1 дүгээрт, Хүнсний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх Хүнсний хувьсгал, Шинэ хоршоо, Атар 4 зэргийн аянуудын хэрэгжилтийг эрчимжүүлнэ.

2 дугаарт, тээвэр логистикийг засах боомтын хүчин чадал, чингэлгийн урсгалын удирдлага хил, гаалийн бүрэн цахимжилтуудыг хэрэгжүүлнэ. Энэ чиглэлээр тусгай зөвшөөрлүүдийн тоог цөөрүүлсэн бодитой алхам ажлууд хэрэгжиж эхэлсэн байгааг мэдээлье.

Мөнгөний бодлого Монгол банк 2025 оны үндсэн чиглэлийн дагуу 2027 оноос 5%-ийн инфляцыг 5 хувьд хүргэх зорилт руу мөнгөний бодлоготой төсвийн бодлогыг нягт уялдуулна.

3 дугаарт, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2025 оны 7 сард 15,6 их наяд болж, өмнөх оны мөн үеэс 1,2 их наяд төгрөгөөр буюу 7,4%-аар бага байна. Үүнд нүүрсний үнэ огцом буурч уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого буурч, ААНОАТ 28%-аар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр буюу АМНАТ 2,2 дахин буурсан нь голлон нөлөөллөө.

Энэ хуулийн төсөлд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг дараах байдлаар тооцож тусгалаа.

2026 онд 31,6 их наяд, 2027 онд 33,7 их наяд, 2028 онд 37,3 их наяд байхаар тооцлоо. Төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаснаас 2026-2028 онуудад 1,8 их наяд төгрөгөөр тус тус бууруулан тооцлоо. Ингэснээр тэнцвэржүүлсэн орлогын ДНБ-д эзлэх хувь 2026 онд 30,9, 2027 онд 29,3, 2028 онд 28,2 хувьд хүрч буурна. Энэ нь татварын ачааллыг хөнгөрүүлж, хувийн хэвшлийн орон зайг тэлнэ. Өнөөдрийн хэлэлцүүлж байгаа олон нийтээр хэлэлцүүлж байгаа хараахан өргөн баригдаагүй байгаа татварын цогц реформын үр дүнд татварын ачааллыг 3-4 их наядаар жилд бууруулахаар тооцоолсон. Татварын реформын төслийг хэрэгжүүлж байгааг та бүхэндээ мэдээлье.

4 дүгээрт, төсвийн нийт зарлага 2025 оны 7 дугаар сарын байдлаар 16,9 их наяд төгрөгт хүрсэн. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1,6 их наяд төгрөг буюу 10,9%-аар өслөө. Энэ өсөлтөд цалин хөлсний зардал өмнөх оны мөн үеэс 27,2%-аар, тэтгэвэр тэтгэмжийн зардал 14,4%-аар өссөн нь ийм шийдвэр гарсан нь голлон нөлөөллөө.

Уг хуулийн нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээг дараах байдлаар тооцож тусгалаа.

2026 онд төсвийн нийт зарлага 33 их наяд төгрөгөөр буюу ДНБ-ий 32,2%-аар, 2027 онд 34,6 их наяд буюу ДНБ-ий 30%-аар, 2028 онд 37,8 их наяд төгрөг буюу ДНБ-ий 28,6% байхаар төсөөллөө.

Зарлагын ДНБ-д эзлэх хувийг үе шаттай бууруулснаар төсвийн сахилга батыг чангатгаж, мөнгөний бодлоготой уялдуулна. Үр дүнд нь төрийн оролцоо хумигдаж, хувийн хэвшлийн орон зай тэлж, инфляц саарч, зээлийн хүү буурах бодит нөхцөлийг бүрдүүлэх юм.

Тав дугаарт, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны эхний 7 дугаар сарын байдлаар 1,3 их наяд төгрөгийн алдагдалтай байна. Эдийн засгийн өсөлт 2026 онд өнгөрсөн хавар тооцож байснаас илүү саарах төлөвтэй байгаа учраас мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлж, иргэд, хувийн хэвшлээ дэмжих бодит шаардлага үүсээд байна. Тиймээс нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2026 онд 1 их наяд 380 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1,3%-тай тэнцэх дүнгээр алдагдалтай баталж хэрэгжүүлэхээр төсвийн хүрээний мэдэгдэлд тусгалаа.

Харин 2027-2028 онуудад тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 0,8%, 0,4% болгон тус тус бууруулахаар хуулийн төсөлд тусгалаа.

6-д, суурь зарлагыг төсвөө төсвийн хүрээний мэдэгдэлд дараах байдлаар төсөөллөө. Нийт зарлагаас эх үүсвэртэй зардлыг хасаж тооцсон дүн буюу нэгдсэн төсвийн суурь зарлагын хэмжээг 2026 онд 29,6 их наяд төгрөг буюу ДНБ-ий 28,9 хувь, 2027 онд 31,4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 27,3%, 2028 онд 33,2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 25,1% байхаар тооцлоо. Суурь зарлагын хэмжээг батлагдсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулахад 2026 онд 0,8 их наяд төгрөгөөр, 2027 онд 1,8 их наяд төгрөгөөр буюу 1 их наяд 800 тэрбум төгрөгөөр, 2028 онд 3,2 их наяд төгрөгөөр тус тус бууруулан тооцлоо. Суурь зарлагын харьцааг бууруулах нь сахилга батыг сайжруулж инфляцыг хазаарлан тогтвортой байдлыг хангахад чиглэгдэнэ.

7-д, нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2026 онд 2 их наяд төгрөг, 2027 онд 2,3 их наяд төгрөг, 2028 онд 2,7 их наяд төгрөг, суурь тэнцлийн ДНБ-д харьцах харьцааг 2026-2028 онд 2%-тай тэнцүү байхаар уг хуулийн төсөлд тусгасан. ДНБ-ий харьцааг 2026-2028 онд 2,0%,-ийн түвшинд хадгална. Энэ нь Засгийн газрын өр төлбөрийг шатлан бууруулах бодлого юм.

8-д, Засгийн газрын нийт өрийн хэмжээг 2025 оны 2 дугаар улирлын байдлаар 35,5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 39,5%-тай тэнцэж байна. Энэ хуулийн төсөлд Засгийн газрын өрийн дээд хязгаарыг шат дараатай бууруулж, 2026 онд ДНБ-ий 50%, 2027-2028 онд ДНБ-ий 45% байхаар тооцлоо. Энэ нь улсын зээлжих зэрэглэлийг тогтворжуулж төр ба хувийн хэвшлийн гадаад зах зээлээс бага хүүтэй хөрөнгө босгох нөхцөлийг сайжруулж, зээлийн хүү буурах нөхцөлийг бүрдүүлнэ.

9 дүгээрт, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмжийн зардал 2025 оны 7 дугаар сард 1,4 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 6,5%-аар өслөө. Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу төсвөөс хуваарилах зардлын ДНБ-д эзлэх хэмжээг төрөөс халамжийг зохистой түвшинд байлгах хэт халамжид суурилсан бодлогоос татгалзах зорилгоор 2026 онд 2,6%, 2027 онд 2,4%, 2028 онд 2,2% байхаар энэ хуулийн төсөлд тусгасан болно. Халамжийг хөдөлмөр эрхлэлттэй уялдуулж

зорилтот бүлэгт чиглүүлэх тэтгэвэр тэтгэмжийн тогтолцоог шинэчилж үр ашгийг дээшлүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Энэхүү төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагуудыг бүрэн хангасан болно. Үүнд төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцож, нүүрс зэсийн үнийг тэнцвэржүүлсэн аргачлалаар тусгасан. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийг 2026-2028 онд ДНБ-ий 2%-ийн ашигтай түвшинд хадгална. Нэгдсэн төсвийн урсгал зарлагыг 2026 онд ДНБ-ий 24% буюу хуульд заасан 30%-аас доогуур түвшинд барина. Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг ДНБ-нд эзлэх хэмжээг 2026 онд 50%, 2027-2028 онд 45% түвшний бодлогын хүрээнд мөрдөгдөнө.

Олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэдээс ирсэн саналыг тооцоололд тусгасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь орлогоо тэнцвэржүүлж, суурь тэнцлээ ашигтай хадгалж, өрийн дарамтыг үе шаттай бууруулж, хувийн хэвшлийг идэвхжүүлж, хүний хөгжилд өгөөжтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилготой.

Тиймээс Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг бэхжүүлэх, сахилга ба үр ашгийг дээшлүүлэх зорилготой Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайдад баярлалаа. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1.5.2 дахь заалтын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд дүгнэлт гаргах үүргийг хүлээсэн байдаг.

Дүгнэлт гаргахдаа Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тодорхойлолт, эдийн засгийн агуулга, бүтцийн талаарх Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зохицуулалт Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн баримталж буй бодлого чиглэлийг бид харгалзан үздэг.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын төсвийн бодлогын хувьд төсвийн хууль, эрх зүйн орчны чанар, тогтвортой байдал, хэрэгжилт, төсөв нь макро эдийн засгийн хөгжил тогтвортой өсөлтийг дэмжсэн байх, эдийн засаг дахь төрийн

оролцоог бууруулах төсвийн зарлагын оновчтой бодлогыг хэрэгжүүлэх тал дээр онцгой анхааран ажиллаж байна.

2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчны шаардлагыг хангасан бүтэц агуулгын хувьд харьцангуй сайжирсан байна.

Мөн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хувьд дараах эерэг, сөрөг асуу, зарим асуудлууд байгааг цаашид улам сайжруулах, анхаарах шаардлагатай байгааг дурдах нь зүйтэй гэж үзэж байна.

Эдийн засгийн өсөлтийн таамаглалыг өмнөх жилүүдийн хэт өөдрөг түвшнээс багасгаж 5,7% буюу төсвийн тогтвортой байдлын зөвлөл олон улсын байгууллагуудын таамаглалтай ойролцоо түвшинд харьцангуй бодитой таамагласан нь төсвийн бодлогыг макро эдийн засгийн нөхцөл байдлыг зөв харж төлөвлөх шаардлагатай нийцэж байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Төсвийн тогтвортой байдлын хуульд орсон өөрчлөлтийн дагуу төсвийн орлого зарлагыг бууруулсан төдийгүй 2018 онд төсвийн нийт зарлага ДНБ-ий 29 хувьтай тэнцэж байсан 2024 онд 38,3% болж даруй 9,3 нэгжээр өссөн энэ төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлаж, төсвийн хэт тэлэлтийг зогсоогоод чиглэсэн эхлэл болж байгаа нь эерэг хандлага юм.

Дээр дурдсан бодлогын эерэг өөрчлөлтүүдийг дурдахын зэрэгцээ төсвийн бодлого, хууль, эрх зүйн орчны хэрэгжилтийн хувьд анхаарах зарим зүйлс байна. Үүнд:

1 дүгээрт, төсвийн мөчлөг сөрсөн бодлогыг тууштай хэрэгжүүлж, төсвийн эрсдэлийг бууруулах тухай асуудал байна. Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд мөчлөг сөрсөн төсвийн бодлогын тухай ихээхэн дурдаж, төсвийн зарлагыг тэлэх арга хэрэгсэл болгодог байдлаас татгалзаж, эдийн засгийн тэлэлтийн үед ч энэ арга хэрэгслийг байнга санадаг байж төсвийн ирээдүйн эрсдэлийг бууруулахад анхаарах нь хүнд нөхцөл байдалтай тулгарсны дараа хариу үйлдэл үзүүлэхээс илүү оновчтой юм.

2 дугаарт, төсвийн зарлагын оновчтой түвшнийг олж тодорхойлох, төлөвлөх тухай асуудал. Төсвийн зарлагыг бууруулж, цар тахлын өмнөх түвшинд хүргэхийг зорьж байгаа нь сайн хэрэг боловч энэ нь Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тодорхойлсон хувь хэмжээнд хараахан хүрээгүй байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тодорхойлсноор төсвийн зарлага ДНБ-ий 27%-тай тэнцэж байх нь өсөлтөд хамгийн эерэг нөлөөтэй гэж үзсэн байна. Зарлага нь оновчтой түвшнээс гадна төсвийн алдагдал макро эдийн засгийн үр нөлөөтэй эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай бөгөөд алдагдалгүй төсвийн талаарх үзэл баримтлал нь хэрэгжиж чадаагүй үлдэж байгааг дурдахыг хүсэж байна.

3 дугаарт, Төсөв макро эдийн засгийн эрсдэл дунд хугацаанд үргэлжлэхээр байна. 2020-2024 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын жилийн дундаж өсөлт 26,2% байсан бол нэрлэсэн ДНБ-ий өсөлт 17% байсан. Хэрвээ энэ

хандлага цаашид хэвээр үргэлжилбэл 3 жилийн дотор буюу 2028 онд урсгал зардлын ДНБ-д эзлэх хүү 30%-аас хэтрэх буюу төсвийн тусгай шаардлага зөрчигдөх нөхцөл үүсэж болзошгүй байна. Засгийн газраас боловсруулсан Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан шинэчлэлийн төсөвт үзүүлэх шууд нөлөө нь Сангийн яамны тооцоолсноор 4 их наяд орчим төгрөг байгаа нь ДНБ-ий 3-4%-тай тэнцэх буюу мөн хэмжээний төсвийн алдагдал үүсгэж, төсвийн тэнцлийн тусгай шаардлагууд 2027 оноос зөрчигдөхөөр байна. 2023 онд Монгол Улс анх удаа төлбөрийн болон төсвийн тэнцлийн хувьд ашигтай гарсан нь эдийн засгийн хувьд ихээхэн эерэг үзүүлэлт болж чадсан. Энэ нь хараахан удаан хадгалагдаж чадаагүй бөгөөд 2024 онд тэнцлийн хос алдагдалтай гарсан. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл төлбөрийн тэнцлийн мэдээллээс харахад төсөв, төлбөрийн тэнцэл нь 2025 онд алдагдалтай гарахаар байгаа бөгөөд 2026 онд ч энэ байдал давтагдах эрсдэлтэй байна. Ингэснээр төсөв урсгал тэнцлийн хос алдагдлын мөчлөгт эдийн засгийг оруулж болзошгүй. Энэ нь төлбөрийн тэнцэл валютын нөөцөд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн дархлааг сулруулах үр дагавартай гэдгийг сануулж байна.

4 дүгээрт, сүүлийн жил гаруйн хугацаанд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь агуулга бүтцийн хувьд сайжирч, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.3-д заасан агуулгыг хамрах байдал нь харьцангуй сайжирсан ч макро эдийн засгийн тогтвортой байдал төсвийн бодлогын нөлөөллийн талаар хийсэн дүн шинжилгээ, макро эдийн засгийн төлөв байдал дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтийг тооцоход хэрэглэсэн аргачлал, тооцооны үндэслэл, төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор тооцсон нэгдсэн төсвийн тэнцэл, улсын хөрөнгө оруулалт, төсвийн нийт орлого, зарлагыг багтаасан төсвийн гол үзүүлэлтүүд, тэдгээрийн төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнтэй нь харьцуулсан харьцуулалт зэрэг нь хангалтгүй байгаа тул энэ чиглэлээр хуулийн хэрэгжилтийг цаашид сайжруулах шаардлагатай байна. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь Монгол Улсын төсвийн бодлогын гол бичиг баримт болохын хувьд тогтвортой өөрчлөлтгүй хэрэгжиж байх, макро эдийн засгийн өөрчлөлт төсвийг даган өөрчлөгдөж түүний тулд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт хийж байгаа нь цаашид анхаарах нэг гол асуудал юм.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг макро эдийн засгийн нөхцөл байдал, хөгжлийн бодлогод нийцтэй, төсвийн мөчлөг сөрсөн бодлогын үзэл баримтлалын хүрээнд сайн төлөвлөж, хуулийг чанд мөрдүүлж байж төсвийн бодлого түүний хэрэгжилтэд эерэг нөлөөллөө үзүүлж чадна гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төлөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн дүгнэлтийг товч танилцууллаа.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Гомбожавын Занданшатар Монгол Улсын Ерөнхий сайд, Ням-Осорын Учрал Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Тогмидын Доржханд Монгол Улсын Шадар сайд, Сайнбуянгийн Амарсайхан Монгол Улсын Шадар сайд, Сандагийн Бямбацогт Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын

дарга, Батмөнхийн Батцэцэг Гадаад харилцааны сайд, Болдын Жавхлан Сангийн сайд, Лхагвын Мөнхбаатар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Дамбын Батлут Батлан хамгаалахын сайд, Батын Батбаатар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Пүрэвсүрэнгийн Наранбаяр Боловсролын сайд, Тилеуханы Аубакир Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Борхүүгийн Дэлгэрсайхан Зам, тээврийн сайд, Чинбатын Ундром Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Энхтайваны Бат-Амгалан Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Энхбаярын Батшугар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Жигжидсүрэнгийн Чинбүрэн Эрүүл мэндийн сайд, Лхагвын Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга, Нямсүрэнгийн Мөнгөнцэцэг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Сандагийн Магнайсүрэн Монгол Улсын Ерөнхий аудитор, Пүрэвээгийн Дэлгэрнаран Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Барсүрэнгийн Баасандорж Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Намжилдоржийн Энхбаяр Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Түндэвийн Жамбаажамц Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Батмөнхийн Батдаваа Үндэсний статистикийн хорооны дарга, Дугарын Сүнжид Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын комиссын дарга, Гаваасүрэнгийн Азжаргал Авлигатай тэмцэх газрын дэд дарга, эрхэлсэн комиссар, Даньхүүгийн Баянбилэг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Содномцэрэнгийн Заяадэлгэр Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Гочоогийн Ганболд Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх, Лхагважавын Гангэрэл Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Жамсрандоржийн Дэлгэрсайхан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Лангааны Отгонтуяа Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Равсалын Ренчинбазар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Нинжбатын Ууганбаатар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Амаржаргалын Энхбат Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн, Ганболдын Энхтайван Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Сүрэнжавын Гансэлэм Монгол Улсын Ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга, Дашживаагийн Ариунболд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга, Доржсүрэнгийн Мөнхзориг Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга, Баярсайханы Баярдаваа Монголбанкны Мөнгөний бодлогын газрын захирал, Идэшийн Батхүү Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Хаш-Эрдэнийн Сүрэнхорол Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бат-Ирээдүй Анар Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга, Даринчулууны Эрдэнэтуяа Эдийн засаг, хөгжлийн яамны Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга, Төмөрийн Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Батболдын Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Лхагвасүрэнгийн Балчинлувсан Эдийн засаг, хөгжлийн яамны Бизнесийн орчны бодлогын газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганболдын Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж Эдийн засаг, хөгжлийн яамны Төсвийн хүрээний төлөвлөлтийн хэлтсийн дарга, Цасчихэрийн Мөнхдэлгэр Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн бодлого, төсөөллийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Ингээд илтгэл, дүгнэлттэй холбогдуулан Ерөнхий сайд, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Ардчилсан намын бүлгийн дарга, Ардчилсан намын дарга Цогтгэрэл даргад микрофон өгье.

О.Цогтгэрэл: Эрхэм гишүүддээ 2025 оны намрын ээлжит чуулганы мэндийг мөн бас Монгол Улсад орчин цагийн парламент үүссэний 35 жилийн ой, өнөөдөр 9 дүгээр сарын 15-ны өдөр олон улсын ардчиллын өдрийн мэндийг та бүхэндээ хамтатган хүргэе.

Өнөөдөр Монгол Улсын 2026 оны улсын төсөв мөн Төсвийн тухай хууль болоод Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж эхэлж байна. Тэгэхээр энэ хуулиудын хүрээнд Ардчилсан намын бүлгээс Улсын Их Хурлын тухай хууль болоод Дэгийн тухай хуульд заасны дагуу завсарлага авах санал гаргаж байгаа юм.

Ер нь ямар учир шалтгаантай вэ гэж.

1 дүгээрт нь Төсвийн тухай баримт бичиг нь өөрөө дунд хугацааны төлөвлөлттэйгөө зарчмын хувьд нийцэж байх ёстой гэсэн хуулийн үзэл санаанууд байдаг. Олон олон зүйлүүд. Гэтэл энэ удаагийн Улсын Их Хурал дээр 2026-2030 оны Монгол Улсын 5 жилийн төлөвлөгөө гэдэг бичиг баримт одоо орж ирээгүй, хэлэлцэгдэн батлагдаагүй. Тэгэхээр 5 жилийн төлөвлөгөөгөө бид нар хэлэлцээгүй, батлаагүй байж байж 1 жилийн төлөвлөлтийг шууд барьж авч хэлэлцэж эхлэх нь хэр зарчимд нийцэх вэ. 1 дүгээрт нь.

2 дугаарт нь төсөв гэдэг өөрөө Төсвийн тогтвортой байдлын болоод бусад хуулиудад заагдсан төсвийн хүрээ, хязгаарын хүрээнд төсөвлөн орж ирэх ёстой. Төсвийн хүрээ хязгаарын хүрээнд төсөвлөн орж ирэх ёстой. 3 сарын өмнө бид нар төсвийн хүрээний мэдэгдлийг баталсан. Гэтэл одоо өмнөх 3 сарын өмнө баталсан төсвийн хүрээ хязгаарын хүрээнд биш шинэ төсвийн хүрээ хязгаарыг дагуулан оруулж ирж хэлэлцэж эхлэх гэж байна. Тэгэхээр энэ өөрөө бас төсвийн болоод бусад хуулиудын зарчимд хэр зэрэг нийцэж байгаа вэ гэдэг асуудлыг бас нягтлан шалгах ийм шаардлагууд үүсэж байна. Бас эдгээр дүгнэлтүүдийг ч бас саяын танилцуулсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн багийн танилцуулгад бас тодорхой дурдагдаж байгааг бас сонслоо. Ийм учраас Ардчилсан намын бүлгээс 2026 оны төсөвт бас макро дүгнэлт хийх, хөрөнгө оруулалт бусад зүйлүүд дээр эрэмбэ дараагийн асуудлуудыг ярилцах олон олон энэ шаардлагын үүднээс Ардчилсан намын бүлгээс дотооддоо ажлын хэсэг гараад, Улсын Их Хурлын гишүүн Түвшинээр ахлуулж, ажиллаж бас тооцоо судалгаа хийлгэх ийм шаардлага үүсэж байна гэж үзээд Ардчилсан намын бүлгийн зүгээс энэ удаагийн төсвийн төсөөллийн тухай төсвийн хүрээний мэдэгдэл, 2026 оны улсын төсөв болон дагалдах хуулиуд дээр ажлын 5 хоногийн завсарлага хүсэж байна. Завсарлагын асуудлыг шийдэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр 2 асуудал байна л даа. 2 асуудлыг асуудал тус бүрээр нь завсарлага асуу авах асуудал 1 дүгээрт нь хөндөгдөх ёстой.

2 дугаарт 5 хоногийн завсарлага өгөхөөр төсвийн хэлэлцүүлгийг 5 үе шаттай болгож одоо Монгол улсын хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцэж байна гэж кноп дарахад урьдчилаад 14 хоногийн хэлэлцүүлгийн хугацаа хэрэгтэй гэдэг байдлаар Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулсан. Тэгэхээр хэт урт хугацаагаар

завсарлага өгөхөөр бас энэ ач холбогдол буурах талтай учраас арай цөөн хоногоор завсарлага өгье гэж бодож байгаа юм.

Тэгэхдээ асуудал тус бүр дээр ярих нь зүйтэй байх гэж бодож байна. Нөгөө талаасаа шинээр нэмэлт, өөрчлөлт орсон Улсын Их Хурлын тухай хуулийн өөрчлөлт нь 15-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдаан нээлтээ хийгээд, тухайн өдөртөө төсвөө хэлэлцэж эхэлсэн байх хуулийн заалттай болсон. Тэгэхээр яах вэ, эхний энэ төсвийн хүрээтэй холбоотой асуудал дээр хугацаа зааж завсарлага өгөөд төсвөө бас албан ёсоор хэлэлцэж эхлээд, эхэлсний дараа завсарлага авах асуудлаа ярих нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд ач холбогдлоо бодоод мэдээж Ардчилсан намын бүлгээс завсарлага авъя гэж байгаа учраас өгөхгүй байх боломжгүй. Тийм учраас 2 өдрийн завсарлага өгчихвөл та бүхэн маань бас суугаад ажиллачих боломж гарчих болов уу гэж бодож байна. Цогтгэрэл дарга аа, Тэгэх үү. Тэгээд 2 өдрийн завсарлага өгөөд, 3 дахь өдөр /Лхагва гараг/-т чуулган хуралдаж, үргэлжлүүлж хэлэлцэхээр өгье. 5 өдрөөр өгөхөөр бас асуудал байна. 4 дэх өдөр, 5 дахь өдөр 2 хугацаатай бас хэлэлцэх асуудлуудтай.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Улсын Их Хурлын тогтоолд тавьсан хоригийг хэлэлцэж эхлэхээс өгсүүлээд асуудал байгаад байгаа юм. 2 өдрөөр өглөө. 3 дахь өдөр чуулган үргэлжилнэ.

14.49 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн нэг дэх хэлэлцүүлгийг хийнэ.

Төслийн талаарх танилцуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий даяар тарифын дайн, геополитикийн зөрчилдөөний хүнд сорилт үргэлжилж байна. Цар тахлын сүүдэр бүрэн арилаагүй, дэлхийн дэг журам ганхаж цаг төр үймээнтэй байна. Уур амьсгал эрс өөрчлөгдөж, дэлхий нийтээр ган гачиг байгалийн эрсдэл ээлжлэн нэмэгдэж байна. Иймд тодорхойгүй таамаглахад бэрх цаг үед бид улс орон, ард түмнийхээ ирэх жилийн ажил амьдрал, ирээдүйг төлөвлөхөөр энд чуулж байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг та бүхэнд танилцуулж байна. 2024 оны сүүлээс нүүрсний үнэ унаж, экспорт хумигдаж, төсвийн орлого тасарч, валютын нөөц буурч, төгрөгийн ханш сулран, үнэ ханшийн өсөлт эрчимжиж эдийн засгийн өсөлт эхний улиралд 2,4% хүртэл 2 дахин буурсныг та бүхэн санаж байгаа. Ингээд энэ нөхцөл байдал үргэлжилсэн бол инфляц 15% хүрэх, төгрөгийн ханш 4 мянга давж сулрах, төсвийн орлого 3,3 их наяд төгрөгөөр тасалдах, төлбөрийн тэнцлийн алдагдал 1 тэрбум долларт хүрэх бодит эрсдэл нүүрлэсэн байсан. Шинэ Засгийн газар ийм хүнд сорилттой нүүр тулж, ачааны хүндийг ард түмэн, аж ахуйн нэгждээ үүрүүлэхийн оронд төр өөрөө бүсээ чангалах ийм шийдвэр гарч, төсвийн зардлыг

танан, 2025 оны төсөвт хэмнэлтийн тодотгол хийж, төсвийн зарлагыг 2,2 их наядаар бууруулсан. Цаг алдалгүй авсан энэ шийдвэр зах зээлийн хүлээлтийг тогтворжуулж, айл өрхийн халаасыг тэмтэрч байсан үнийн өсөлт саарч, эдийн засгийн өсөлт 2 дахин нэмэгдсэн. Ингээд энэ 2 сар гаруй хугацаанд бид төсвийн орлогыг нэмэгдүүлэх, экспортыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Тухайлбал, Тавантолгой Эрдэнэс Тавантолгой ХХК-д 7 дугаар сарын 9-ний өдөр онцгой дэглэм тогтоож, бүрэн эрхт төлөөлөгчдийн зөвлөл томилж хамтын удирдлагын зарчмыг хяналттай хэрэгжүүлснээр ердөө 2 сарын дотор нүүрсний олборлолт, тээвэр, борлуулалт 1,6 дахин өсөж, үр ашиг 3 дахин нэмэгдсэн. Экспорт богино хугацаанд сэргэж орлого, ашиг нь мэдэгдэхүйц нэмэгдлээ. Үүний үр дүнд валютын нөөц 5,7 тэрбум долларт хүрч, 7, 8 дугаар сард төлбөрийн тэнцэл дараалан ашигтай гарлаа. Бүхэлдээ төрийн өмчийн компаниудад хэрэгжүүлж байгаа шинэчлэл үр ашгийн менежментийн шинэчлэлийн хүрээнд зардлыг бууруулж, орлогыг нэмэгдүүлэх төлөвлөгөө баталснаар ирэх жилийн төсөвт төлөвлөж байснаас 1 их наядаар ашгийг нэмэгдүүлэх төсөвт төвлөрүүлэх орлогыг 590 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх даалгавар өгч төсөвт тусгалаа.

Ингэж өөрчлөлт шинэчлэлүүдийг хэрэгжүүлж чадсанаар инфляц тогтворжиж, эдийн засгийн өсөлт нэмэгдэж байна. Баялгийн өгөөж ард түмэндээ хүрч бүрэн очиход хаана хэрхэн замхарч байгааг албан тасалгааны цонхоор биш газар дээр нь очиж ажиллах, суусан цэцнээс явсан тэнэг дээр гэдэг энэ зарчмыг баримталж, газар бүрд хүрч ажиллалаа. Тухайлбал, Тавантолгой ажиллаж, Эрдэнэс Тавантолгойд ажиллаж баялаг монгол хүндээ хүрэхэд тээг болж буй санаатай, санаандгүй бодлого зохион байгуулалтын алдаа саадыг судлан шинжилж, өөрчлөлтийн төлөвлөгөө баталж, мөрдүүлж хэрэгжүүллээ.

Энэ гарааны 100 хоногтоо Засгийн газар хурж овоорсон бэрхшээлүүдийг бодлогоор бодит ажлаар даван туулахыг зорьсон. Бага ярьж бидний ажлын үр дүн чанга дуугарахыг зорьсон. Өнөөдрийг ирээдүйтэй нь хамт танадаг аливаа хулгайтай хатуу тэмцэхийн зэрэгцээ баялгийн менежмент засаглалыг засаж залруулах шаардлага ямар бодитой амин чухал болохыг харууллаа.

Эрүүл мэндийн салбар дахь ахиц бол зүгээр нэг үзүүлэлт биш. Монгол хүний эрүүл явах эрх, хүний хувь заяа улаан бурхны эсрэг дархлаажуулалтыг богино хугацаанд 95% хүргэснээр өдөрт 600 давж байсан өвчлөл 3-аас 4 болж 200 дахин буурлаа. Энэ бол хүүхэд бүрийн амьдрал гэр бүлийн итгэл найдвар юм. Өргөсөн тангарагтаа үнэнч бяцхан иргэдийнхээ төлөө нойр хоолгүй зүтгэсэн цагаан нөмрөгт баатрууддаа чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Өнөөдөр хойд бүсийн иргэд хот руу биш нутагтаа хавдрын иж бүрэн төвөөс оношилгоо эмчилгээ авах бүрэн боломжтой боллоо. Шинэ төв нээлээ. Эрт илрүүлсэн онош бүрийн ард элэг бүтэн амьдрал, амьд явах эрх оршдог. Тиймээс хавдартай тэмцэх нь Монгол төрийн үүрэг Засгийн газрын онцгой даалгавар гэж үзэж хавдрын эсрэг цогц хөтөлбөр хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн яам ажиллаж байна.

Гэвч эрүүл мэндийн салбарт оршиж байгаа бодитой бэрхшээлүүдийг энэ төсвөөр бүрэн биш юм гэхэд тодорхой хэмжээгээр шийдэхийг зорьсон.

Эрчим хүчний салбар онцгой байдлыг шаардаж байгаа. Ийм учраас өндөржүүлсэн бэлэн байдлын дэглэм тогтоож, Засгийн газар хяналтдаа авч ард түмнээ дааруулахгүй даван туулах бэлтгэлийг урьдчилан хангаж ажиллаж байна. Төрийн данхар бүтцийг цомхотгон үрэлгэн зардлыг хязгаарлаж, татвар төлөгчдийн мөнгийг тоог чанараар нь хэмнэх, ард иргэдээрээ хянуулах шинэ үеийг эхлүүллээ.

Ийм учраас төсвийн төлөвлөлт бол иргэдийн оролцоотой, төсвийн хэрэгжилт бол иргэдийн хяналттай, төсвийн тайлагнал бол иргэдийн үнэлгээтэй байх ийм шинэ зарчмыг бүрдүүлэхээр журамлалаа. Яамдын газар, хэлтсийг 81-ээр, агентлагийн удирдлагыг 54-өөр бууруулж, зөвхөн 16 яаманд 168 оронтой цомхотголоо. Уялдаа холбоогүй 26 үндэсний хороо, зөвлөлийг татан буулгаж зөвлөлд шилжүүлснээр данхайсан бүтэц агшиж, үргүй зардал хумьж, төрийн алба илүү чадварлаг, бүтээмжтэй болох бодит өөрчлөлт хэрэгжиж эхэлсэн. Ирэх жилд энэ өөрчлөлт шинэчлэлт тууштай үргэлжлэхээр ирэх жилийн төсвийн хуульд суулгалаа.

Төрийн өмчит компаниудын удирдлагын орон тоог 200-аар цөөлж, 11,5 тэрбум төгрөгийн зардлыг хэмнэлээ. Баруун бүсийн эрчим хүчний 9 компанийг 4 болгон нэгтгэж, хил гаалийн шат дамжлагыг 40%-аар бууруулан бизнесийг боож байсан 55 төрлийн зөвшөөрлийг хүчингүй болголоо. Төрийн царцсан өмч хөрөнгийг ард түмэндээ буцааж, эргэлтэд оруулж байна. Айлаас ирэхийн оронд авдраа уудал гэдэг шиг тоосонд дарагдсан үл хөдлөх хөрөнгийг сэргээн сургууль, цэцэрлэг, эмнэлэг болгох шийдвэр гаргаж, иргэдэд ойрхон үйлчилгээ үзүүлэхээр шийдвэрлэлээ.

Дампуурсан банкнуудаас төрийн авлагыг буцаан төвлөрүүлэх, төрийн өмчийг хамгаалан олон жил сунжирсан асуудлыг ассет менежмент буюу хөрөнгийн удирдлагын ажлын хэсэг байгуулан цэгцлэн ажиллаж байна.

Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг тууштай хэрэгжүүлж, баялагтаа эзэн Монгол зорилгыг үг биш үр дүнгээр хэрэгжүүлж харуулахыг зорьж байна. Тухайлбал Төгрөг нуур, Төмөртэй овоо зэрэг стратегийн ордуудыг төрийн мэдэлд тодорхой хүүдийг буцаан авч, өгөөжийг нь өргөн олонд хүртээх ажлыг эхлүүллээ.

Оюут шинэ ордыг Эрдэнэтийн үйлдвэрийн газарт илрүүлснээр 357 сая тонн зэсийн нөөцийг шинэчлэн тогтоож, Эрдэнэт үйлдвэр ирэх 100 жил тогтвортой ажиллах бат бөх өнцөг бүрдлээ. Эрдэнэт бол тэжээлийн цэгийн үнээ биш 100 дамнах баялгийн булаг, саалийн үнээ болохыг дахин нотоллоо.

Засгийн газар гарааны 100 хоногтоо эхлүүлсэн амжилтуудаа бататгаж, стратегийн ордуудын өгөөжийг ард түмэндээ нэмэгдүүлэх хэлэлцээрийг улам эрчимжүүлнэ гэдгийг онцлон тэмдэглэе. Энэ ганц 2 ордыг онцлох биш Монгол Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа 1763 лиценз тус бүрийг лицензийн тооллого АМНАТ-ийн тооллогыг эхлүүлж, лиценз болгоны олголт, хариуцлагыг тодотгож, баялгийн сангийн үр өгөөжийг нэмэгдүүлэх ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Бэрхшээл нэгэн зэрэг арилдаггүй. Бүх юм өргөс авсан юм шиг нэг өдрийн дотор сайжрахгүй. Гэхдээ энэ бодлогууд эхний 100 хоногт эдийн засгийн бодит сэргэлт болж эхэлсэн. Хэрэв бид ажлын хүндийг дааж, ахиц дэвшлээ бататгаж чадвал Монгол Улсын өмнө илүү өргөн боломж, илүү том амжилт угтаж байна. Энэ талаар бид төсвийн хүрээний мэдэгдлийг танилцуулахдаа хэрэгжүүлж байгаа бодит төсөл хөтөлбөрүүдийн талаар, ажлын явцын талаар тодорхой мэдээлсэн.

Дэлхийн дэвжээнд тугаа мандуулж байгаа монгол охид, хөвгүүдийн адил хамтын хүчээр бид гадаа хүйтэн байхад дотроо дулаан байж, эвлэж байж, хамтарч байж Монгол Улс урагшилна.

Эрхэм гишүүд ээ,

Ард иргэдийн санал хэрэгцээ үнэлгээ шаардлагад тулгуурлаж түүхий эдийн үнэ ханш гадаад дотоодын эрсдэлийг харгалзан тооцсон Монгол Улсын 2026 оны төсвийг өнөөдөр өргөн танилцуулж байгаагаас гол агуулгуудыг та бүхэнд товчхон танилцуулъя.

Төсөв бол төрийн өмч бус ард түмний хөлс хүч, хөдөлмөрийн дусал бүрээр бий болсон хуримтлал, татварын мөнгө, төсвийн зарлага бүрийн ард татвар төлөгчид баялаг бүтээгчдийн халаас байдгийг төрийн байгууллага, албан тушаалтан бүр эрхэмлэн санаж байх учиртай. Тиймээс 2026 оны төсөв бол татварын дарамт ачааллыг 3-4 их наяд төгрөгөөр бууруулах шинэ эхлэл. Данхар төрийг хумьж сахилга бат хариуцлагыг чангалж бататгах шинэ алхам. Өсөлтийг өрх бүрийн үүдээр оруулж иргэн бүрд хаяглан хүргэх хүний хөгжлийн мега төсөл. Иргэдтэйгээ хамт боловсруулсан иргэдтэйгээ хамт хэрэгжүүлэх иргэд дараа нь үнэлэх 240 мянган хүний санал бодол шингэсэн түүхэнд анх удаа иргэдтэйгээ санал авч боловсруулсан зөвшилцлийн төсөв юм.

Төсвийн төслөө боловсруулахдаа 239,8 мянган иргэнтэй уулзан ярилцаж, санал бодлыг нь салбар бүрээр хэлэлцүүлэг зохион байгуулан сонссон. И-Монголиа системээр санал бодлоо ирүүлсэн 188 мянган иргэний дуу хоолой, хүсэл сонирхлыг тусгалаа. Ирэх оныхоо төсвийг боловсруулахад санал санаачилгатай ажилласан эдгээр иргэн бүрдээ Монгол Улсын Засгийн газрын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байна.

Ард түмний элч төлөөлөгч Улсын Их Хурлын эрхэм гишүүд Та бүхэн иргэдийнхээ санал бодлыг онцгойлон анхаарч, хүндэтгэн харгалзана гэдэгт гүнээ итгэж байна. Ард түмний хүсэл нийгмийн захиалга тодорхой байна. Эрүүл мэнд, боловсрол, эрчим хүчинд илүү их хөрөнгө оруулах, хавтгайрсан халамжийг хязгаарлах, татвар хураамжийн ачаалал дарамтыг хөнгөлөх энэ 3 асуудал руу ард иргэдийн санал ам нэгтэйгээр дэмжиж байна.

Төсөв бол зүгээр нэг тооны нийлбэр биш, мөрөөдлийн тоо ч биш. Тийм учраас бодит байдалд тулгуурлаж хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх учиртай. Ийм бодит тоо. Тийм учраас тэр тоо юу өгүүлж байна вэ гэдэг нь хамгийн чухал. Төсөв бол чанар өгөөжийн хэмжүүр авах ёстой. Ийм учраас иргэдийнхээ хүсэл нийгмийн захиалгатай нийцүүлж, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг 5,5 дахин нэмэгдүүллээ. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтыг 2 дахин нэмэхээр төлөвлөлөө. Гадаад зээл тусламжийг эдгээр чиглэлүүдэд түлхүү чиглүүлж, үр дүнд хүргэхээр тооцлоо. Энэ бол ард иргэдээс ирүүлсэн захиа даалгавар онцгой даалгавар юм. Ийм учраас 2026 оны төсөвт ХСҮТ 2, Зүрх судасны үндэсний төвийг шинээр барьж байгуулах, Гэмтэл согогийн үндэсний төвийг өргөтгөн бэхжүүлэх, 17 аймгийн яаралтай болон эрчимт эмчилгээний тасгийг иж бүрнээр шинэчлэх, эрүүл мэндийн салбарын цогц шинэчлэлийн бодлогууд оролцсоноор эрүүл мэндийн салбарт хийгдэж байсан хөрөнгө оруулалт 5,5 дахин өслөө.

Боловсролын салбарын хөрөнгө оруулалт 1,2 их наяд байсан бол 2,4 их наяд төгрөг болж 2 дахин өссөн. Нийслэлийн сургуулиудын ачааллыг бууруулахаар 117 шинэ сургууль, 73 шинэ цэцэрлэг, 32 дотуур байр барихаар ирэх жилийн төсөвт суулгалаа. Хүүхэд бүр дэлхийн монгол иргэний хэмжээнд эрдэм мэдлэг эзэмших, багш бүр хийснийхээ хэрээр цалинжих нөхцөлийг бүрдүүлэхийн тулд боловсролын жилд зориулж урсгал төсвийг нь 100 тэрбум төгрөгөөр нэмэгдүүллээ. Хэдийгээр төсвийн зарлага ихээхэн унаж байгаа боловч ахмад настнуудынхаа тэтгэврийг үнийн өсөлттэй уялдуулж дундаж тэтгэврийг 901 мянган төгрөгт хүргэхээр тусгалаа. Хүнээс гал, гэрэл гуйдаггүй болох зорилгоор эрчим хүчний хараат байдлаа бууруулж, 3,9 их наяд төгрөгийн дотоод хөрөнгө оруулалтаар эрчим хүчний эх үүсвэрээ нэмэгдүүлэхээр төлөвлөлөө. Үйлдвэрлэлээ 3.5 сая мвт цагаар нэмэгдүүлснээр импорт багасаж, цахилгааны тасалдал, тарифын дарамт багасна.

Монгол хэмээх нэгэн айл бусдаас гэрэл, дулаан гуйдаг биш өөрөө галаа манадаг, өөрөө галаа бадраадаг байх гэсэн зарчмаар сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх хувийн хөрөнгө оруулалтын санаачилгыг дэмжүүлсэн бодит ажлуудыг эхлүүлсэн.

Эрхэм гишүүд ээ,

Ерөнхий сайд, эдийн засагч хүний хувьд миний барьж буй томоохон зорилт бол татварын 3 дахь шатын иж бүрэн шинэчлэл юм. Энэ шинэчлэл бол ард иргэд баялаг бүтээгчдээ бодитоор дэмжиж, татварын ачааллыг 3-4 их наяд төгрөгөөр хөнгөлөх түүхэн эхлэлтэй төсөв юм. Бид баялаг бүтээгчдээ дэмждэг, баялгийн хулгайчтай тэмцдэг байж байж татварын шинэчлэлээ бас бодитой хэрэгжүүлж чадна. Бид иргэндээ ойрхон шинэчлэлээ зөвхөн өөрсдийн санаачилгаар бус улс орнуудын сайн туршлага, загварууд, эрдэмтэн судлаачид, эдийн засагчид, иргэний нийгмийнхээ үнэтэй санал зөвлөмж байр сууринд үндэслэн тулгуурлаж хамтран боловсрууллаа. 2026 оноос эхний дорвитой алхмаа эхлүүлнэ. Төсвийн цогц реформын багц хууль бол D-Parliament болон Монгол Улсын Засгийн газраас ард иргэдтэйгээ хэрэгжүүлж байгаа зөвлөлдөх ардчилал ард түмэнтэйгээ зөвлөлддөг D-Government гэдэг ийм цахим платформоор санал хэлэлцүүлгээ эхлүүлсэн. Энэ 2026 оны төсөвтөө бол далд эдийн засгийг ил болгож, татварын реформынхоо суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд оруулж байгаа реформ өөрчлөлттэй зөвхөн энэ хэсгийг нь урьдчилгаа нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төсөвтэй хамт өргөн мэдүүлж байна.

Ирэх иргэн бүрийн сарын 1 сая төгрөгийн худалдан авалтын буцаан олголтыг 2 биш 5 хувь болгож нэмэгдүүлж байна. Ингэснээрээ далд эдийн засгийг ил болгох, тэр хэмжээгээрээ татвар төлж байгаа иргэд буцаан авалтаа нэмэгдүүлэх ийм боломж олгож байгаа юм. Ингэснээр ард түмний 80% буюу сард 1 сая хүртэл төгрөгийн худалдан авалт хийж байгаа 4 ам бүлтэй айл гэхэд 4 сая төгрөгийн худалдан авалт хийж байгаа айл өөрөөр хэлбэл 10 монгол хүн тутмын 8-ынх нь халаасанд 2,5 дахин их үлдэнэ. Ард түмний карманд илүү мөнгө үлдэж НӨАТ-ын ачаа дарамт 2 дахин багасна. 3 гишүүнтэй өрх 3 сая төгрөгийн худалдан авалт хийдэг бол 60 мянга биш 150 мянган төгрөг, жилдээ 1 сая 500 мянган төгрөг нэмж авах бололцоо бүрдэнэ гэсэн үг. 2027 оноос буцаан олголтыг нэмэгдүүлж, сар бүрийн 500 мянган төгрөг худалдан авалтын нэмэгдсэн өртгийн албан татварыг бүрэн буцааж олгодог болохоор төлөвлөлөө. Энэ бол шударга иргэн төвтэй эрүүл шинэ татварын тогтолцооны эхлэл юм. Ингэснээрээ далд эдийн засгийг ил болгож, татварын бааз суурийг өргөжүүлж, татварын цогц реформыг хэрэгжүүлэх суурь

нөхцөлийг бүрдүүлэх юм. НӨАТ бол зөвхөн татвар биш, бүртгэлийн систем, далд сүүдрийн эдийн засгийг ил гаргах хөшүүрэг юм. Тиймээс нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг нэмэгдүүлснээр далд эдийн засаг гэрэлд гарч эрүүлжиж эмчлэгдэнэ. Төр түмэн нүдтэй болж ард иргэдийн арын хаалгагүй шууд хараа хяналт тогтоно. Орлого багатай иргэд илүү үр өгөөжийг нь хүртэнэ. Мөн татварын бодлогоороо нийтийн сайн сайхны төлөөх хариуцлагыг дэмжинэ.

Эрүүл мэнд, боловсролын салбарт хөрөнгө оруулсан хувийн хэвшил борлуулалтын орлогынхоо 1 хувийн татварын хөнгөлөлтийг эдлэх болно. Энэ бол төр, хувийн хэвшил, иргэн 3-ын хамтын шинэ соёлын эхлэл байх болно.

Шийтгэдэг бус зөвлөдөг, хаадаг бус сэргийлдэг, дарамталдаг бус дэмждэг хүнлэг татварын тогтолцоонд шилжүүлнэ. Ингэснээрээ бид Баялаг бүтээгчдийг дэмжих багц хууль, Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулиудыг хувийн хэвшилтэйгээ хамтран боловсруулж өргөн мэдүүлэхээр манай Эдийн засаг, хөгжлийн яам ажиллаж байна.

Татварын шинэчлэлийн багц хуулийн төсөл D-Parliament цахим системд ил тод байршсан. Хүссэн хүн бүхэн гар утаснаасаа санал өгч хэлэлцүүлэгт оролцож болно. Эрхэм гишүүд та бүхэн иргэнээ дээдэлсэн энэхүү иж бүрэн татварын шинэчлэлд ард иргэдийнхээ санал бодлыг сонсож, ажил хэрэгчээр хамтран ажиллана гэдэгт миний бие гүнээ итгэлтэй байна. Та бүхнийг цахимаар болон бодитоор энэ ажлын хэсэгтэй хамтран ажиллахыг уриалж байна.

Эрхэм гишүүд ээ,

Үндэсний баялгийн сан бол өвөг дээдсээс өвлүүлсэн эх орны үүц нөөц, иргэн бүрийн үнэт өв, өргөн олон түмний хамтын хуримтлал юм. Засгийн газар Үндэсний баялгийн сангаа өсгөн арвижуулж баялагтаа Эзэн Монгол эрхэм зорилгын хүрээнд үгээр бус үйл хэргээр, амтар бус ажлын үр дүнгээр нотлон харуулахын төлөө ухрахгүй тэмцэж урагшлан зүтгэх болно. Энэ хүрээнд Тавантолгойн бүлэг ордын ашиглагдаагүй нөөцийг эдийн засгийн эргэлтэд оруулж, баялгийн үр өгөөжийг иргэддээ шударгаар хүртээх, тэгш хүртээх зарчимд тулгуурлан Үндэсний баялгийн санг арвижуулна. Хуримтлагдсан баялгаа эрүүл мэнд, боловсрол, орон сууц зэрэг иргэдийн амин чухал хэрэгцээнд бодитой зориулж хэрэгжүүлэх нь Засгийн газрын бас нэг онцгой даалгаврын нэг болж байна.

Ипотекийн тогтолцоог шинэчилж, энэ зорилгоор тусгайлсан орон сууцын банк Орон сууцын санхүүжилтийн институтыг байгуулж, олон айл өрхийн өмнө шинэ орон сууцын Affordable housing буюу орлогод нийцсэн хямд өртөгтэй орон сууцны нийлүүлэлтийг дэмжих, нөгөө талдаа хүү багатай, босго намтай, урт хугацаатай зээлийн шинэ тогтолцоог төр, хувийн хэвшил, олон улсын хамтын ажиллагаагаар бий болгохоор зорьж, энэ тогтоолын төсөлд агуулгыг нь суулгалаа. Ингээд энэ ирэх жилийн морин жил, морин цагт шинэ сууцдаа нүүн орох 80 мянган айлын орон сууцын хөтөлбөрийг манай Барилга, хот байгуулалт, орон сууцжуулалтын яамнаас боловсруулж байна. Энэ чиглэлээр бас манай гишүүд санаачилгатай ажиллаж, ажлын хэсэг байгуулж байгаа гэж сонссон. Ингээд хамтран ажиллахыг уриалж байна. Орон сууц бол зөвхөн барилга байшин биш энэ бол монгол айл өрхийн амьдрах орчин, ажилгүйдэл, ядуурал, агаарын бохирдол, гэр бүл салалт зэрэг нийгмийн олон асуудал, шалтгааныг шийдэх суурь түлхүүр гэж үзэж энэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа юм.

Улс орны хөгжил дэвшил, аюулгүй байдлын өөр нэг түлхүүр бол зам дэд бүтэц. Өргөн уудам нутагтай Монгол оронд тээвэр логистикийн гацаа бөглөө арилгахын хэрээр цаг мөнгө хэмнэж, эдийн засгийн судсыг тэлнэ. 2026 онд бүсчилсэн хөгжлийн замын бүтээн байгуулалтыг эрчимтэй үргэлжлүүлж, 1,2 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3122 км зам, 3159 метр зам гүүрийг шинээр барьж засварлана. Авто замын хөрөнгө оруулалт бол бүсчилсэн хөгжлийн болон салбар бүрийг зах зээлтэй холбох амьд судас гэж үзэж, энэ чиглэлээр гадаадын зээл тусламж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллахаар төлөвлөсөн.

Замын-Үүд, Гашуунсухайт, Боршоо, Сүхбаатар, Алтанбулагийн боомтын хүчин чадлыг 2-3 дахин нэмэгдүүлсэн бол 2026 онд Бичигт, Цагаан дэл уулын өргөтгөл шинэчлэлийг эхлүүлж, Цагаан нуур Булган хавирганы шинэ боомтыг Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр барьж эхэлнэ.

Эрхэм гишүүд ээ,

2026 оны төсөв бол эдийн засаг дахь төрийн данхайсан давилуун давруут оролцоог багасгаж, төрийн оролцоог харьцангуй хумих тийм шинэ эхлэл юм. Төр бол чөлөөлөгч байх учиртай. Төрийн оролцоо ихдэх тусам хувийн хэвшилд шахагдаж боломж хумигддаг. Харин төрийн оролцоо багасахын хэрээр хувийн хэвшил тэлж хүчтэй болдог нь энгийн бөгөөд бодит зүй тогтол. Тиймээс 2026 оны төсөв бол төрийн зуршлыг хязгаарлаж, хувийн хэвшлийг чөлөөлөх замын зураг гэж үзэн Ардын намын анхны дарга Солийн Данзан иргэн баян бол улс баян гэж 100 жилийн өмнө хэлсэн үг өнөөдөр түүхийн хуудсанд бус төрийн бодлогын зүрхэнд дахин бичигдэж байна. Энэ бол өнгөрсөн түүх биш, өнөөдрийн хийх ажил, биелүүлэх үүрэг даалгавар гэж бид үзэж байна. Засгийн газар өдөр тутмын ажлынхаа төвд үргүй зардлыг танах, сахилга, хариуцлагыг чангатгах бодлогыг тавьсан. Тиймээс ДНБ-ий 35,1 хувийг эзэлж байсан төсвийн зарлагыг 32,2% болгож бууруулан, урсгал зардлыг 26,6%-аас 24% болгож танаж, сахилга бат, хариуцлагыг бэхжүүлж байна. Энэ төсвөөр ашиг бус алдагдал үйлдвэрлэдэг ТӨК-удыг татан буулгаж, нэгтгэн цомхотгож, зах зээл чөлөөт өрсөлдөөний орон зайг нээж өгч байна. Үр дүнд нь ТӨК-удын тоог 109-87, төрийн албан хаагчдын тоог 230-мянгаас 218 мянга болж буурна.

2026 оноос төрийн өмчит компаниудын худалдан авалтыг бүрэн цахимжуулж, хүний оролцоог багасгаж, хиймэл оюун ухааныг нэвтрүүлж эхэлнэ. Эрдэнэт үйлдвэр жишээлбэл худалдан авалтдаа шахаа хулгай гэж нэрлэгдсэн тендерийн булхайг залруулах зорилгоор хиймэл оюун ухааныг туршиж эхэлсэн нь ил тод, эрүүл, шударга засаглалыг тогтоон бэхжүүлэхэд гаргасан бодит жишээ, сайн санаачилга болж байна. Энэ хиймэл оюун ухааныг ашигласан тендер худалдан авах ажиллагааны шинэчлэлийг Эрдэнэс Монгол, Эрдэнэс Тавантолгой компаниудад хэрэгжүүлэхээр дараагийн шатад бэлтгэлээ ханган ажиллаж байна.

Монголчууд бид уул уурхайн түүхий эдийн үнэд хэт найдсан түүхээ өөрчлөх учиртай. Байгалийн баялгаас гадна эдийн засгаа олон тулгууртай болгож, бизнес эрхлэгчдээ хөрөнгө, зах зээл, дэд бүтцээр дэмжсэнээр эдийн засгаа төрөлжүүлж, эдийн засгийн аюулгүй байдал, эдийн засгийн хамаарлаа бууруулж чадна. Аялал жуулчлал бол 1 долларыг 2 доллар болгон өсгөдөг. 600 гаруй мэргэжлийн хүнд шууд орлого олгодог нүүдлийн өв соёлоо дэлхийд таниулдаг ийм үнэтэй салбар.

Энэ салбарт 267 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, 150 гаруй аж ахуйн нэгжийн дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулна.

Хүнс эрүүл бол хүн эрүүл хүн эрүүл бол Монгол Улс эрүүл хүчирхэг байна. Иймээс хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг бүрэн хангахын зэрэгцээ экспортын боломжоо тэлнэ. Малын тоо толгой өсөн үржиж байгаа ч үр шим нь ахихгүй. Цагаан алт, ноос ноолуур, арьс ширээ, жалганд хаяж, улмаар жил бүр 190 сая долларын ноолууран хувцас арьс ширэн бүтээгдэхүүнийг импортолж байна. Энэ бол бодит үнэн. Тиймээс малчид тариаланчдынхаа хүч хөдөлмөрийг бодит өгөөж болгохын тулд Цагаан алт, Шинэ хоршоо, Атрын 4 дүгээр аян зэрэг бодлого хөдөлгөөнөө үр дүнтэй үргэлжлүүлнэ. Ирэх онд 995,7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 15 мянга гаруй иргэн, аж ахуйн нэгж, хоршоодод олгож, үйлдвэрлэл, бүтээн байгуулалтыг нь бодитоор дэмжинэ. Ингэснээрээ бид 184 сая хүн ам 2,4 треллион их наяд долларын эдийн засаг зах зээлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнээ экспортлох боломжийг шинээр нээж байна.

Монгол Улсын 2026 оны төсөв бол иргэдийн хүсэл зорилго, санал зөвлөмжөөр боловсруулагдсан ардчилсан зөвшилцлийн төсөв юм. Энэ бол татварын ачааллыг ард түмний нуруунаас хөнгөлж, данхар төрийн оролцоог хумьж, хүн чанартай бодлогын шинэчлэл эхлүүлсэн төсөв гэж үзнэ.

2026 онд төсвийг мөнгөний бодлоготой уялдуулснаар эдийн засгийн өсөлтөө 5,7 хувьд хүргэх, инфляцыг 7%-аас давуулахгүй хязгаарлах, экспортыг 16,7 тэрбум долларт хүрэх зорилтуудыг дэвшүүлж байна. Төсвийн орлогоо 31 их наяд 600 тэрбум төгрөг, төсвийн зарлагаа 32 их наяд 980 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 1 их наяд 380 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар тооцлоо. Гадаад зах зээл, түүхий эдийн үнийн төлөв, дотоодын эдийн засгийн эрсдэл боломжийг нягт харгалзан төсвийн орлогоо аль болох бодитой, хэрэгжихүйц байдлаар төлөвлөхийг зорилоо. Улсын төсөв бол Монгол хэмээх нэгэн их өрх айлын орлого, зарлага амьдрал ахуй ямар байхыг шийдэх суурь хуулиудын нэг юм. Татвар төлөгчдийн хөдөлмөрийн төсөл бүр зөв зарцуулагдаж, ард иргэдийн амьдралд бодит үр өгөөжөө өгөх ёстой. 2026 оны төсөв бол тоо бус чанар, мөнгө бус хүнд чиглэсэн хэлбэр бус агуулгыг эрхэмлэсэн хүний хөгжлийн төслийн үндэс нь юм.

Ард түмний элч төлөөлөгч болсон эрхэм гишүүд ээ,

200 гаруй мянган иргэдийнхээ санал хүсэл эрмэлзлийг шингээсэн ардчилсан зөвшилцлийн төсвийг улс орныхоо язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, хамтдаа шүүн, хэлэлцэн баталж, ирээдүйгээ хамтдаа бүтээцгээхийг уриалж байна. Мөнх хөх тэнгэрийн хүчин дор Монгол Улс минь мандан бадрах болтугай.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Сандагийн Магнайсүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

С.Магнайсүрэн: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны

төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн аудитын тайлан, дүгнэлтийг Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлсэн.

Тус аудитын зорилго нь Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлж, төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлэн боловсруулсан эсэхийг хянаж дүгнэхэд чиглэлээ.

Засгийн газар Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа иргэд, олон нийтийн саналыг авч хэлэлцүүлэг зохион байгуулсан нь сайшаалтай байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1-д заасан шалгуурт нийцэж байгаа эсэхэд хийсэн аудитаар дараах дүгнэлтийг өгч байна. Үүнд:

1.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцдог байх, нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн ДНБ-ий 2 буюу түүнээс дээш хувийн ашигтай байх, нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн ДНБ-ий 30%-аас хэтрэхгүй байх, Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны дүнгээр тооцсон ДНБ-ий 60%-аас хэтрэхгүй байх гэсэн тусгай шаардлагуудыг хангаж байна.

2.Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болон үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт агуулгын хувьд нийцэж байгаа боловч улсын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бүрэн чиглүүлэх шаардлагатай байна.

3.Засгийн газрын өрийн үлдэгдэл 2026 онд ДНБ-ий 43,8%-тай тэнцүү байхаар төсвийн төсөлд тусгасан нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.2.3-д заасан төсөв, санхүүгийн аюулгүй байдлын бодлогын зохистой харьцаанд нийцэж байна. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл батлагдаагүй байгаа тул 2026 оны төсвийн төслийг боловсруулах шатад байгаа бодлогын баримт бичгийн төсөлд үндэслэж нийцсэн эсэхийг дүгнэх боломжгүй байна.

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31 их наяд 600 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 30,9%, нийт зарлага ба цэвэр зээлийн хэмжээг 32 их наяд 980 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 32,2%, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 1 их наяд 380 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий 1,3%-тай тэнцүү байхаар төлөвлөжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд 579 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2024 оноос 56%-аар, 2025 оноос 55,5%-аар буурсан. Мөн нийт санхүүжилтийн 66,8%-ийг шилжих арга хэмжээнд хуваарилснаар улсын төсвийн хөрөнгө оруулалтыг улс бүсийн хөгжлийн бодлогын томоохон зорилтуудад чиглүүлж өмнөх оноос үргэлжлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах

нөхцөлийг бүрдүүлсэн сайн талтай байгаа боловч дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай байна. Үүнд:

1.Монгол Улсын 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төсвийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн нь төсвийн удирдлагын зарчим, сахилга батыг сулруулж, дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн ач холбогдлыг бууруулахад хүргэж байна.

2.Төсвийн төслийг боловсруулах, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллагуудын салбар хоорондын уялдаа хангалтгүй, тооцоо судалгаа, мэдээллийн эх сурвалж зөрүүтэй байгаа нь төсвийн төсөл бодлогын баримт бичгүүдтэй бүрэн нийцэж байгаа эсэхийг нэгтгэн дүгнэхэд хүндрэлтэй, Хөгжлийн бодлогын баримт бичгийн нийцэл бүрэн хангагдахгүй, холбогдох хууль тогтоомж бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

3.Төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлаар хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулахгүй байгаа нь төсвийн төлөвлөлтийн үр ашгийг бууруулж байна.

4.Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд гол нэр төрлийн эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнэ буурч төсвийн орлого тасрах эрсдэл үүссэн нөхцөлд төсвийн зарлагыг санхүүжүүлэх үүсэх эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээ, төсвийн бодлогод тодорхой тусгагдаагүй байгааг тус тус анхаарах.

Аудитын дүгнэлтэд үндэслэн Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхэнд дараах 2 асуудлыг толилуулж байна. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулах бүрд Төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчлөх, хуулийн төслийг хамт өргөн мэдүүлж дунд хугацааны төсвийн төлөвлөлтийн үр нөлөөг бууруулж, төсвийн тогтвортой байдлын зарчмыг алдагдуулахгүй байх, Төсвийн төслийг дагалдуулан хууль тогтоолын төслүүдийг өргөн мэдүүлэхдээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлагуудыг бүрэн хангуулах зэрэг болно.

Монгол Улсын Засгийн газарт тухайн жилийн төсвийн төслийг төсвийн тогтвортой байдлын зарчмыг баримтлан төсвийн тусгай шаардлагыг хангаж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн боловсруулж өргөн мэдүүлэх⁸ Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогоос эрсдэлийн сан байгуулж төсөвт тусгаж байх. Төсвийн үр ашгийг дээшлүүлж, төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн тэвчиж болох зардлыг төсөвт төлөвлөхгүй байх арга хэмжээ авч бүх шатын төсөв захирагч нарт энэ жиг талаар чиглэл өгч ажиллах гэсэн 3 зөвлөмжийг өглөө.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд буюу Эдийн засаг, хөгжлийн сайдад улсын төсвийн төсөл нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцэж байгаа эсэх асуудлаар зөвшөөрөл өгөх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллах, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийг төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан хянах, Монгол Улсын ирэх 5 жилд баримтлах үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулж батлуулах, төсөв зохиох, тооцоолох суурь үндэс болсон

ТЭЗҮ боловсруулах ажлын нэгж өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоож, хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хянахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зэрэг 5 зөвлөмжийг өглөө.

Сангийн сайдад тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилах, хөгжлийн бодлого, төлөвлөлттэй бүрэн уялдуулах, төсвийн ерөнхийлөн захирагч нарын жилийн төсвийн хязгаарыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд болон төсвийн тусгай шаардлагад нийцүүлж, тооцоо судалгаанд үндэслэн бодитой тооцох, улсын төсвийг төсөвлөх, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн санал авахдаа төсвийн тухай хуулийг чанд мөрдөх, төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж үр ашигтай байдлыг нэмэгдүүлж санхүүгийн сахилга батыг сайжруулах зэрэг 9 зөвлөмжийг өглөө.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдад төрийн байгууллагуудад ашиглах компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норм стандартыг салбарын онцлогт уялдуулан боловсруулах, цахим систем боловсруулах ажлын өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоох ажлыг Сангийн яамтай хамтран хэрэгжүүлэх зэрэг 2 зөвлөмжийг өглөө.

Бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт тухайн онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсөв, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулах хариуцсан салбарын барилга байгууламж, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг, төсөв зэрэг хөрөнгө оруулалттай холбогдох мэдээллийг агуулсан иж бүрэн өгөгдлийн санг бий болгох зэрэг 6 зөвлөмжийг тус тус өгөөд байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөлд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь Эрхэм гишүүд та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Та бүхэнд Монгол Улсын 2026 оны төсвийн төгсгөлд хийсэн аудитын дүгнэлтийн талаар товч танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Төсвийн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх дүгнэлтийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга Намжилдоржийн Энхбаяр танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Энхбаяр: Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийг 9 дүгээр сарын 1-ний өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16.1.5.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8.4.8 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай

хуулийн 23.1 дэх заалтын дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлд дүгнэлтээ гаргалаа.

Бид дүгнэлтээ гаргахдаа өргөн мэдүүлсэн төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгасан Төсвийн тусгай шаардлагад нийцсэн эсэх, 7.3-д заасан төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ гэснийг баримталсан эсэх, Монгол Улсын төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйл, 6.2.1, 6.2.2, 6.3.3, 6.4.1, 27 дугаар зүйл, 32.2-т заасны дагуу боловсруулагдсан эсэхэд анхаарсан.

Монгол Улсын 2026 оны төсвийн төслөөс үзэхэд макро эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн бодлогын чиглэлийг тодорхойлж олон нийтийн оролцоог хангаж байгаа зэрэг ахиц дэвшил гарсныг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь төсвийн төслийн хэлэлцүүлгийн явцад Улсын Их Хурал, Засгийн газар, харьяа байгууллагууд олон нийтийн оролцоотойгоор төсвийн тулгамдсан асуудлыг олон талаас нь шүүн хэлэлцсэний эерэг үр дүн юм гэж үзэж байна. 2010 онд батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт алдагдаж байсан зарим он жилүүдтэй харьцуулахад 2026 оны төсвийн төсөл, төлөвлөлт нь тодорхой хэмжээгээр сайжирсан бөгөөд цаашид бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийн түвшинд анхаарах асуудал цөөнгүй байна.

Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь төсвийн тусгай шаардлагуудыг хангасан байна. Өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн төсөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1-д заасан тусгай шаардлагыг хангасан байна. Төсвийн тухай хуульд төсвийн төсөл нь хөгжлийн төлөвлөлттэй нийцтэй байх талаар хуулийн 27.1.8-д улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх гэж заасан заалтыг тодорхой хэмжээгээр хангажээ.

Улсын Их Хурал 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдөр 48 дугаар тогтоолоор Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг батлан гаргаж, уг төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл арга хэмжээг 2026 оны төсвийн тухай хуульд тусган боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд нийт 316 төсөл арга хэмжээ тусгагдсанаас 126 төсөл нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих бөгөөд үүнээс 60% буюу 76 төсөл, арга хэмжээг 2026 оны төсвийн төсөлд тусгасан байна. 2026 оны төсвийн төсөл нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй тодорхой хэмжээгээр нийцтэй байна. Гэхдээ төсвийн төсөл хөгжлийн төлөвлөгөөний нийцтэй байдлыг бүрэн хангах асуудлыг цаашид тодорхой хэмжээгээр анхаарах шаардлагатай зарим асуудлууд байна.

Монгол Улсын төсвийн бүрдэл хэсгүүдийн талаар гарсан зарим дүгнэлтийг та бүхэнд товч танилцуулъя.

Улсын төсвийн орлого төлөвлөлтийн талаар:

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого тусламжийн дүнд Үндэсний баялгийн сангийн орлогын эзлэх хувь цаашид өсөх хандлагатай байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын бүрдүүлэлт эрсдэлтэй, төсвийн татварын бус орлого

буурах хандлагатай байна. Улсын төсвийн орлого нь түүхий эдийн экспортын биет хэмжээ болон дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай хэвээрээ байна. Улсын төсвийн орлого экспортод гаргаж байгаа түүхий эдийн биет хэмжээ дэлхийн зах зээлийн үнээс ихээхэн хамааралтай байгаа нь төсвийн орлогыг тогтвортой бүрдүүлэхэд эрсдэл дагуулсаар байна.

Төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага ба цэвэр зээлийн өсөлт 2025, 2026 онд аажим саарах хандлага ажиглагдаж байна. Эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулахаар төлөвлөсөн байна. ДНБ-д эзлэх төсвийн зарлагын хэмжээ 2018 онд 29% байсан бол 2021 онд 37,1 хувьд хүрч өссөн. Улмаар 2022 онд 33,9%, 2023 онд 29,2% болж буурсан ч гэсэн 2024 онд дахин 38,3 хувьд хүрч өссөн. Төсвийн нийт зарлага 2025 онд 35,1 хувьд хүрэхээр хүлээгдэж байгаа бол 2026 онд 32,2% болж буурахаар тооцсон байна.

Төсвийн бодлого зорилтуудыг харилцан уялдааг тодорхойлсон, тодорхойлсон, тодорхойлсон боловч төсвийн зарлага, үр дүнгийн үзүүлэлт, үр дүнгийн үзүүлэлтүүдийн нийцлийг бүрэн хангаагүй байна. Төсвийн төсөлд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарыг онцолсон нь 2026 оны хөгжлийн төлөвлөгөөний хүн төвтэй хөгжлийн үзэл санаатай уялдсан байна. Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэл нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн салбар эдийн засгийн үйл ажиллагаа болж байна. Улсын төсөв ба орон нутгийн төсвийн хоорондын одоогийн харилцааг шинэчлэх замаар бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагатай гэж үзэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар:

Төсвийн хөрөнгө оруулалтыг эрэмбэлж төлөвлөх тогтолцоог зохистой хэрэгжүүлэхгүй байгаа нь хөрөнгөжилтийн үр дүнг бууруулж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлэх эрэмбэлэх тогтолцоо, дүрэм журамд зарим алдаа дутагдал сул тал орсоор байна. Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх хүн амын өсөлтөд суурилсан урт хугацааны төлөвлөлттэй төсвийн хөрөнгө оруулалтыг уялдуулах шаардлагатай гэж үзэж байна. Хөрөнгө оруулалтын зохицуулалтын орчин үр дүнгийн үнэлгээг сайжруулах хэрэгтэй гэж үзэж байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн төслийн талаар Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулан гаргасан дүгнэлтийг эрхэм гишүүд та бүхэнд урьдчилан хүргүүлсэн тул энэ удаад хураангуйлан танилцууллаа.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн нэмж ирсэн гишүүдийг танилцуулъя. Сүрэнжавын Гансэлэм Улсын Ерөнхий прокурорын Хэрэг эрхлэх газрын дарга, Жигжидийн Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Зоригтбаатарын Энхболд Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга,

Жамьяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Даваажавын Гантуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Отгондэмбэрэлийн Мягмардорж түрүүн танилцуулагдсан. Энхтөрийн Батмөнх Сангийн яамны Төсвийн нэгтгэлийн хэлтсийн дарга, Лувсанвандангийн Ичинноров Сангийн яамны Төсвийн орлогын хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга, Шаравын Бат-Эрдэнэ Сангийн яамны Санхүүгийн хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Рэгзэнгийн Мягмаржав Татварын ерөнхий газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга.

Ингээд төсвийн танилцуулгууд хийгдэж дууслаа. Дүгнэлтүүд хийгдэж дууслаа. Одоо танилцуулга, дүгнэлт болон төсвийн төсөлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгөхөөр байгаа. Цогтгэрэл дарга микрофон авах билүү. Цогтгэрэл дарга.

О.Цогтгэрэл: Монгол Улсын 2026 оны төсөв болоод дагалдан өргөн баригдсан хуулиуд дээр Ардчилсан намын бүлгээс завсарлага авах хүсэлтээ бас дахин илэрхийлж байна. Завсарлага авах шалтгааныг бас өмнө нь хэлсэнтэй бас давтан хэлье. Зөвхөн 1 шалтгааныг хэлэхэд л Монгол Улсын 1 жилийн төсөв бол дунд хугацааны төлөвлөлттэй уялдсан байх ёстой. Дунд хугацаа гэдэг нь 3-5 жилээ бид нар ойлгож байгаа. 2026-2030 он хүртэлх 5 жилийн төлөвлөлтийг Улсын Их Хуралд хэлэлцэн батлах шаардлагатай. 5 жилийн төлөвлөлтөө батлаагүй байж, батлах ёстой хууль, төлөвлөлтөө батлаагүй байж 1 жилийн төлөвлөлтөө түрүүлж өргөн барьж байгаа нь энэ бол өөрөө зарчмын хувьд, дарааллын хувьд ингээд буруу ийм жишиг зарчим явж байна гэж жишээ нь олон шалтгааны нэгийг үзэж байна. Тэгээд өмнө нь хэлснээрээ Ардчилсан намын бүлгээс энэ асуудал дээр 5 хоногийн завсарлага авах хүсэлтийг хүргүүлж байна. Та бүхэн шийдэж өгөхийг хүсье. Тэгээд завсарлагын дараагаас бид нар бас хоорондоо ярилцаад Ардчилсан намын бүлэг дээр Засгийн газар болоод холбогдох албан тушаалтнууд бас мэдээллээр хангахыг хүсье.

Д.Амарбаясгалан: Ингээд түрүүн бас төсвийн хүрээний мэдэгдэлтэй холбогдуулж завсарлагын асуудал дээр хэлсэн 2 хоногийн буюу /Лхагва гараг/ хүртэл 2 асуудал дээр ингээд хоёулан дээр нь завсарлага өглөө. Лхагва гаргийн өглөө 10 цагаас чуулганы хуралдаан үргэлжилнэ.

15.33 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ